



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • III • № 17

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Х.БАТЧУЛУУН
"МОНГОЛ УЛС
2018 ОНЫ 10
САР ХҮРТЭЛ
БИЕЛҮҮЛЭХ
ХҮНДХЭН
ДААЛГАВРЫГ
АВСАН"

ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖИЛД ХҮРГЭХ
ТУЛГУУР НАЙМАН
ЗАРЧИМ

ЭРДЭНЭСИЙН САНГААС: ЭМЭЭЛИЙН ХАШ ЧУЛУУН ТОНОГ

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Огноо: 2018/03/23

БОДЛОГЫН ХҮҮГ БУУРУУЛАХ ТУХАЙ

Дугаар: 2018/01

Мөрдөж эхлэх огноо: 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж, Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувь болгох, Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5 хувиар, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 12 хувиар тогтоох шийдвэр тус тус гаргалаа.

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн жилийн инфляци 2018 оны 2 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.9 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 8.1 хувьтай байна. Гадаад эрэлт хүлээлтээс сайжирч, экспортын бүтээгдэхүүний үнэ өндөр түвшинд хадгалагдаж төлбөрийн тэнцэл болон эдийн засгийн төлөвт эерэг нөлөө үзүүлж байна. Эдийн засгийн идэвхжилийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэж байгаа хэдий ч жилийн инфляци цаашид зорилтот түвшний орчим тогтворжихоор байна.

Бодлогын энэхүү шийдвэр нь банкны салбарын богино хугацаатай эх үүсвэрийн хүүг бууруулж, улмаар зээлийн хүүгээр дамжин бизнесийн идэвхжилийг дэмжих болно.

Зөвлөлийн хурлын хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ



ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛИЙГ БЭЛЭН БОЛГОЖ ХЭЛЭЛЦҮҮЛЭВ

2018.03.22

УИХ-ын тогтоолын дагуу “Зээлийн хүүг бууруулах стратегийн баримт бичгийн төсөл” бэлэн болоод байна. Тус стратегид зээлийн хүүг бууруулахдаа макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, банкуудын эрсдэл даах чадвар, үр ашиг болон засаглалыг сайжруулснаар зээлийн хүүг бууруулах боломжтой гэж үзжээ. Энэ хүрээнд стратегийн 11 зорилтыг тодорхойлж, стратеги тус бүрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байна. Баримт бичгийг боловсруулах ажлын хэсэг дээрх стратегийг эдийн засаг, банк, санхүүгийн болон бусад салбарынхны дунд өргөн хүрээнд хэлэлцүүлж, тэдний санал дүгнэлтийг хүлээн авав.

Зээлийн хүүг бууруулах стратегид:

1. Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах — инфляцийн зорилтот түвшинг хангах
2. Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын секторын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах

3. Төсвийн сахилга батыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах
4. Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх
5. Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний сувгийн нөлөөг сайжруулах
6. Санхүүгийн долларжилтыг бууруулах
7. Хүчтэй санхүүгийн системтэй болох, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх
8. Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх
9. Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох
10. Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх
11. Төрийн болон санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зэрэг болно.

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох мэдээ:

ХУУДАС

Өргөтсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 30.55 сая ам.долларын санхүүжилт хийгдэв

5

Ярилцлага:

ХУУДАС

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах, хөгжүүлэх нь нэг байгууллагын хийж барах ажил биш

7

Байр суурь:

ХУУДАС

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог хэрхэн сайжруулах вэ?

11

Улаанбаатарын зөвшилцөл:

ХУУДАС

“Улаанбаатарын зөвшилцөл”-ийн 8 зарчим

13

Монголбанк юу хийдэг вэ?

ХУУДАС

Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад макро эдийн засгийн төсөөлөл чухал үүрэгтэй

16

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас... /2018.03.23/

20

Мөнгөн тэмдэгтийн түүх:

ХУУДАС

Гүйг хаан 1206-1248

23

Нийтлэл:

ХУУДАС

Монгол улс 2018 оны 10 сар гэхэд биелүүлэх хүндхэн даалгаврыг аваад байна

24

Судалгаа:

ХУУДАС

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар

27

Банкир:

ХУУДАС

О.Орхон: Монголын банкны салбар олон улсын стандартаас хол зөрөөгүй

30

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

2004 оны нобелийн шагнал – Финн Кидланд, Эдвард Прескот нарын бүтээлээс

36

Санхүүгийн боловсрол:

ХУУДАС

Дэлхийн мөнгөний долоо хоног 2018

38

Банкны салбарын хуулиудын эх бичвэрийг хүлээлгэн өгөв



УИХ-ын 2017-2018 оны намрын чуулганаар батлагдсан Төв банк (Монголбанк)-ны тухай, Банкны тухай болон Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн эх бичвэрийг Монголбанк хүлээн авлаа. Эх бичвэрийг хүлээлгэн өгөх ёслолд Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд тэргүүтэй, УИХ-ын болон Засгийн газрын гишүүд оролцож, ёслол төгөлдөр гардууллаа. Эдгээр хуулиудаас Төв банк (Монголбанк)-ны тухай болон Банкны тухай хууль нь 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх юм. Монголбанк 2016 оноос эхлэн дунд хугацаанд хэрэгжүүлэхээр “Банк санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг санаачилж, 2018 оныг банк санхүүгийн салбарын шинэчлэлийн жил болгон зарлаж, бодлогын тодорхой зорилтуудыг тавин хэрэгжүүлж байна.

Өргөтсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 30.55 сая ам.долларын санхүүжилт хийгдэв



Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн Захирлуудын зөвлөл 2018

оны 03 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн гурав дахь шатны үнэлгээний тайланг хэлэлцэж баталлаа. ОУВС-аас хөтөлбөрийн хэрэгжилт сайн, эдийн засгийн өсөлт нэмэгдэж, төсөв, гадаад валютын нөөцийн гол зорилтууд давж биелэн Монгол Улсын эдийн засаг төсөөлж байснаас илүү хурдацтай сэргэсэн хэмээн дүгнэсэн юм. Үүний үр дүнд манай улсад 30.55 сая ам.долларын хөтөлбөрийн санхүүжилт 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Монголбанкны дансанд шилжин орж, улмаар гадаад валютын улсын нөөцийг энэ хэмжээгээр нэмэгдүүллээ. Ингэснээр тус хөтөлбөрийн хүрээнд ОУВС-аас Монгол Улсад олгосон санхүүжилтийн дүн 152.8 сая ам.долларт хүрэв.

Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцэв



Монголбанк, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, МУИС хамтран “Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага-2018” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт, Экспортын төрөлжилт ба эдийн засгийн өсөлт, Экспортыг дэмжих хөтөлбөрийн нөлөөллийн үнэлгээ, Мега төсөл: Олон улсын туршлага, Монгол Улсын одоогийн нөхцөл байдал, эдийн засагт үзүүлэх нөлөө, Бэлчээрийн доройтол ба малын хөлийн

татварын нөлөө, DMA аргыг ашиглан инфляцийг таамаглах нь, Уул уурхайн хөгжил орон нутгийн иргэдийн амьжиргаанд нөлөөлөх нь, Орон сууцны зээлийн бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө зэрэг сэдвүүдээр үндсэн итгэлүүд тавигдаж, салбар хуралдуунуудаар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, уул уурхайн хөгжлийн стратеги, түүнээс олох орлогын үр ашигтай зарцуулалтын талаар хэлэлцүүлэв

Шаардлага хангасан 41 мянга гаруй иргэний зээлийн мэдээллийг хэвийн ангилалд шилжүүлэв



Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 03 дугаарын сарын 09-ний өдрийн А-60 дугаар тушаалаар Монголбанкны зээлийн мэдээллийн сангаас мэдээлэл солилцох хүрээнд зээлийн лавлагаанд тусгахгүй байх иргэний зарим мэдээллийн нөхцөлийг тодорхойлов. Энэ арга хэмжээний үр дүнд 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зээл, төлбөрөө бүрэн барагдуулж дууссан, чанаргүй зээлийн нэгээс дээшгүй түүхтэй буюу үүрэн болон суурин холбооны үйлчилгээний төлбөрийн зөрчил нь 90 хоногоос дээшгүй хугацааны хэтрэлттэй бол Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаанд тусгагдахгүй байхаар уг тушаалаар зохицуулагдсан ба нийт 41085 иргэний мэдээлэл дээрх нөхцлийг хангаад байна.

Банкны ажилтныг мэргэшүүлэх сургалтын үр дүнг дүгнэв

Монголбанк, ХБНГУ-



ын Хадгаламжийн банкны Олон Улсын Хамтын Ажиллагааны Сан, Монголын Банкны Холбоо хамтран 2017 оны хоёрдугаар сараас Монгол Улсад банкны ажилтныг мэргэшүүлэх онол, практик хослуулсан сургалтыг “Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд банкны ажилтнуудын дунд зохион байгуулж, төгсөгчдөд батламж гардууллаа. Энэхүү сургалт нь банкны салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж, банкны үндсэн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх, урт хугацаанд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангахад чиглэгджээ. Мөн иргэдтэй шууд харилцах банкны ажилтныг нэн тэргүүнд чадавхжуулан, зөвлөгөө өгөх, ур чадварт суралцуулах замаар олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг тус төсөл нь дэмжин ажиллаж байна.

Монголбанк “Монгол алт – 2018” чуулганд оролцов



“Монгол Алт-2018” чуулга уулзалтад Монголбанк оролцож,

Төв банкны алт худалдан авалтын үйл ажиллагаа, алт худалдан авалтыг нэмэгдүүлэх талаар баримталж буй бодлогын талаар цаг үеийн мэдээлэл өглөө. Мөн “Алтны зах зээлийн төлөв, дунд хугацааны чиг хандлага” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлээ. Тус илтгэлд дэлхийн алтны зах зээл дэх эрэлт, нийлүүлэлт, үнийн хэлбэлзэл, цаашдын чиг хандлага, Төв банкуудын алт худалдан авалтын статистик, Монголын алтны зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал зэргийн талаар танилцуулав. Мөн үеэр Монгол улсын Эрдэнэсийн сангийн алтны нөөцийг нэмэгдүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж буй дотоодын алт үйлдвэрлэгч компаниудад Монголбанкны зүгээс шагнал гардуулсан юм.

Монголбанк хэрэглэгчдийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийг тэмдэглэв



Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөрлөгийг зохион байгуулж, санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах өнөөгийн тогтолцоог шинэчлэх хууль эрх зүйн зохицуулалтын өнөөгийн тогтолцоо, Монголбанкны гүйцэтгэж буй үүрэг, цаашдын зорилтын талаар хэлэлцлээ. Мөн өдөр Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах аян”-ы

хүрээнд “Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн Дүнжингарав дахь салбарт үйлчлүүлж буй иргэдэд санхүүгийн аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах, гомдол хүсэлтээ хаана, хэнд хандаж хэрхэн шийдвэрлүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан ба Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас зохион байгуулсан “Цахим орчны хэрэглэгч-2018” зөвлөгөөнд “Цахим худалдааны төлбөр тооцоо” сэдвээр илтгэл тавьж оролцов.



Авто тээврийн хэрэгслийн албан татварыг цахимаар төлөх системийг ашиглалтад оруулав

Монголбанк Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахим системээр дамжуулах” гэрээг байгуулж, тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний вэб портал smartcar.mn цахим системийг амжилттай ашиглалтад орууллаа. Smartcar.mn цахим систем нь Монголд анх удаа авто тээврийн хэрэгслийн албан татварыг онлайнаар төлөх боломжийг бүрдүүлж байгаа юм. Систем хэрэглээнд нэвтэрснээр иргэд ухаалаг утасны аппликейшн болон цахим хуудсаар дамжуулан өөрийн эзэмшиж буй тээврийн хэрэгслийн мэдээллийг хянах, авто тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, зам ашигласны төлбөр, зөрчлийн торгуулийг онлайнаар төлөх боломжийг бүрдүүлж, иргэдийн цаг завьг хэмнэх, татвар хураалтын үйл ажиллагааг хөнгөвчлөх зэрэг давуу талуудыг бий болгов.

МОНГОЛБАНК

БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ

1986-1991: ЗХУ (хуучин нэрээр)-ын Луганск хотын Машин байгууламжийн дээд сургууль, Инженер

2000-2002: СЭЗДС- Эдийн засагч, Банк санхүүгийн Бакалавр

2006-2008: Японы Олон улсын их сургууль-Олон улсын хөгжлийн Магистр

АЖЛЫН ТУРШЛАГА

2000-2002: Монголбанк-БТМТГ, МТХ, програм зохиогч

2002-2006: Монголбанк-БТМТГ, Гадаад төлбөр тооцооны алба, Эдийн засагч

2006-2010: Монголбанк-Валютын газар, Туслах мэргэжилтэн, Нөөцийн мэргэжилтэн

2010-2014: Монголбанк-Эрсдэлийн удирдлагын алба, Эдийн засагч

2014-2017: Монголбанк-ТТБГ, ТБЗХ, Ахлах мэргэжилтэн

2017-одоо Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ, ХӨГЖҮҮЛЭХ НЬ НЭГ БАЙГУУЛАГЫН ХИЙЖ БАРАХ АЖИЛ БИШ

УИХ-ын хаврын чуулганаар Мөнгөн угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн батлахтай холбогдуулж Монголбанкны дэргэдэх Санхүү мэдээллийн албаны дарга Х.Батчулуунтай ярилцлаа.

Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлгээс хийсэн Харилцан үнэлгээний тайланд дурдагдсан гол шаардлагууд юу байв?

Нэн тэргүүнд, хууль, эрх зүйн хүрээнд юуны түрүүнд одоо мөрдөгдөж байгаа Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх тухай хуулийг ФАТФ-ын 40 зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах. Үүнтэй холбоотойгоор дагалдах хуулиудад мөн зохих нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Эдгээр дагалдах хуулийн заримыг дурдвал Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай

хууль гэх мэт байгаа юм.

Түүнчлэн үйл ажиллагааны хүрээнд хэд хэдэн суурь өөрчлөлтийг оруулах шаардлагатай болсон. Үүнд, НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлөөс гарч байгаа шийдвэрүүдийг хэрэгжүүлэх арга механизмыг сайжруулах, төрийн болон хувийн хэвшлийн мэдээлэл солилцоог эрчимжүүлэх, хяналт зохицуулалт гүйцэтгэж байгаа төрийн байгууллагын хяналт, шалгалтыг эрсдэлд суурилсан зарчимаар явуулдаг болох. Мөн хууль сахиулах байгууллагуудын бүтцэд эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийн чадавхийг сайжруулж санхүүгийн мөрдлөгө хийх чадамжийг дээшлүүлэх, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц зохион байгуулалтанд анхаарч техник

технологийн хүчин чадлыг хангалттай төвшинд хүргэж, боловсон хүчинг нэмэгдүүлэх шаардлагатай байна. МУТСТ тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн цар хүрээг тэлж мөнгө угаах гэмт хэрэгт өртөх өндөр эрсдэл бүхий зарим салбарыг хамруулж оруулах, МҮЭ-ийн дотоод хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, хэрэглэгчээ таньж мэдэхэд ажлын ур чадварыг нь дээшлүүлэх зэрэг асуудлууд хөндөгдөж байгаа.

Зөвлөмжийн дагуу хэрэгжилт ямар шатандаа явна вэ, мөн заасан хугацаанд амжиж гүйцэтгэлүүдийг хангахад ямар нэгэн бэрхшээлтэй тулгарч байна уу?

Харилцан үнэлгээний тайлан (ХҮТ)-ийн үр дүнгийн дагуу авч

хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөөг Монгол Улсын ЗГ-ын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хурлаар хэлэлцэж баталсан. Төлөвлөгөө нь нийт 42 төрлийн ажлыг 22 яам агентлаг, Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ) хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан. Ажил дараах таван чиглэлээр хийгдэж байгаа. Үүнд: Хууль эрх зүйн орчин зохицуулалтыг сайжруулах, ерөнхий зохицуулалт зохион байгуулалт, хууль сахиулах байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээ, СМА болон бусад байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг байгаа юм. ХАЗ-ийн гишүүн байгууллагууд бүгд өөр өөрийн чиглэлээр зохих ажлаа хийгээд явж байгаа. Мэдээж асуудал тулгаралгүй яахав. Гэхдээ хоорондоо ярьж хэлэлцээд шийдэж болох асуудлаа зохицуулаад, ажлаа ахиулаад явж л байна. Харин туршлага дутах, бололцоо хомсоос үүдэлтэй удааширч байгаа ажлууд дээр олон улсын байгууллагууд, гадаадын түншүүд их тус дэм болж байгаа.

Манайд мөнгө угаах гэмт хэргийн зүйл ангиар шийтгэгдсэн хэрэг нэг ч тохиолдоогүй байгаа нь хуулийн зохицуулалт хангалтгүй байгаадаа юу, эсвэл өөр хүчин зүйлсээс шалтгаалж байна уу?

Монгол Улсад мөнгө угаах гэмт хэргээр ял авч байсан тохиолдол байхгүй байгаа нь ихээхэн шүүмжлэлийг дагуулж байна. 2011 оноос хойш нийт 4345 хүнийг мөнгө угаасан байж болзошгүй асуудлаар шалгаснаас 46 хэрэг мөрдөн шалгах шатанд шилжүүлсэн байдаг. Тэдгээр 46 хэргээс ердөө 2 хэргийг анхан шатны шүүхээс буруутайг нь тогтоож,

шийтгэл ноогдуулах шийдвэр гаргасан ч Дээд шүүхэд хэлэлцээд хэрэгсэхгүй болгосон байдаг. Эндээс харахад манайд мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо сонгодог утгаараа ажиллахгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа нь үнэн. Энэ талаар ХҮТ-нд дурдагдсан байгаа.

Эндээс үзэхэд бид яагаад энэ асуудалд хайнга хандаж ирэв гэдэг асуулт уншигчдаас тавигдах нь дамжиггүй. Та өөрийн дүгнэлтээ өгнө үү?

“Хайнга хандсан” гэж бас хэлж болохгүй л дээ. Энд нилээн олон хүчин зүйл нөлөөлсөн байх. Хамгийн түрүүнд “мөнгө угаах гэмт хэрэг” гэсэн ойлголтыг хэрхэн ойлгож байгаатай холбож ярих хэрэгтэй байх. Олон нийт энэ төрлийн гэмт хэргийг юуны өмнө хар тамхи, зэвсгийн наймаа, хүний наймаа, терроризм гэсэн улс дамнасан том гэмт хэрэгтэй холбож ойлгодог, харин бодит байдал дээр мөнгө угаах явдал бол том жижиг гэлтгүй гэмт хэргийн замаар олсон ямар ч хөрөнгө мөнгөтэй холбогдоно. Нөгөө талаас хууль сахиулах байгууллага, шүүхийн системд ажиллаж байгаа боловсон хүчний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, Эрүүгийн хуулийн холбогдох заалтыг яаж хэрэглэх тал дээр нэгдсэн шинэ бодлого боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байгаа. ХАЗ-ийн гишүүн байгууллагууд энэ чиглэлээр ажиллаад эхэлсэн гэдгийг дурдах нь зүйтэй болов уу.

Санхүү мэдээллийн алба тухайлбал, сэжигтэй гүйлгээнд хяналт тавьж ажилладгийн хувь, мөнгө угаасан байж болзошгүй сэжиг бүхий гүйлгээний талаарх ерөнхий шинжийг энд хэлж болох уу?

Сэжигтэй гүйлгээний ерөнхий шинжийг дурдвал мэдээж юуны өмнө шилжүүлэх гэж байгаа мөнгөний гарал үүсэл тодорхой бус байна. Мөн ямар зорилгоор мөнгө шилжүүлж байгаа нь тодорхой бус, тухайн шилжүүлэг хийлгүүлэх гэж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн тухай мэдээлэл бас л тодорхой бус, ажил мэргэжил, бизнесийн үйл ажиллагаатай нь тохирохгүй, гүйлгээ нь эдийн засгийн илт үндэслэлгүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлдэг түгээмэл арга, хэлбэртэй ижил төстэй шинж тэмдэг бүхий гүйлгээ, зарим тохиолдолд хэн нэгэн хүн өөр хүний өмнөөс гүйлгээ хийлгүүлж байгаа явдал ч гарна. Гадаад шижүүлэг хийх, хүлээн авах үед дээрх шинжүүдээс гадна тухайн шилжүүлэгтэй холбоотой улс ФАТФ-ын “хар” жагсаалтад багтсан байвал сэжиглэх үндэслэл болно.

Манай улс эрчимтэй хяналтад орсноор ямар хүндрэл хүлээж байна вэ?

Монгол Улс эрчимтэй хяналтанд орсон нь нэн тэргүүнд улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх болно. Эдийн засгийн хувьд энэ асуудал хамгийн түрүүнд бизнесийн хэвийн үйл ажиллагаанд, ялангуяа санхүүгийн хөрөнгө оруулалтад шууд нөлөөлнө. Монголын банкуудтай харилцаж байгаа гаднын банкууд мөнгөн урсгалд тавих хяналтаа илүү нягт болгоно, зарим нь харилцаагаа нэг мөр таслана. Мэдээж орж ирж байгаа хөрөнгө оруулалтын зардал нэмэгдсэнээр дотоодод олгож байгаа зээлийн хүүнд сөргөөр нөлөөлөх болно. Энэ нь та бидний өрхийн орлого зарлагын хуваарилалтад мөн нөлөөлнө.

МУТСТ тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болсон шаардлагын талаар тайлбарлана уу, нэмэлт өөрчлөлтүүд нь нөхцөл байдлыг хэрхэн сайжруулна гэж үзэж байгаа вэ?

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийсэн Харилцан үнэлгээний тайлантай холбогдуулан манай улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор гаргасан зөвлөмжийн дагуу хуулийн төсөлд өөрчлөхөөр болон шинээр тусгахаар заасан зохицуулалт нь Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлэх, НҮБ-ын Аюулгүй зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрсдэлд суурилсан зарчимд шилжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын мөнгө угаахтай тэмцэх дотоод тогтолцоог хөгжүүлэхэд, хоорондын уялдаа холбоог тодорхой, цэгцтэй болгох зорилгыг агуулсан байгаа. Эдгээр нэмэлт болон шинэ заалтууд нь батлагдсанаар МУТСТ тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж нь одоо мөрдөгдөж байгаа ФАТФ-ын 40 зөвлөмжийн шаардлагад нийцэхээс гадна Монгол Улсын санхүүгийн систем бохир мөнгөнөөс ангид болж, улсын нэр хүнд өсөж, гадны хөрөнгө оруулалт татахад эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлэх болно.

Энэ бол мэдээж хэрэг ганц Санхүүгийн мэдээллийн албаны хийж гүйцэтгэх ажил биш байх үүнд төрийн оролцоо илүү их үүрэгтэй болов уу?

Мэдээж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах, хөгжүүлэх нь нэг байгууллагын хийж барах ажил биш л байх. Төр, засгийн дэмжлэггүйгээр яагаад ч урагшлахгүй. Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба Харилцан үнэлгээний тайлангийн урьдчилсан дүн гармагц шуурхай арга хэмжээ авч Монгол Улсын Аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт мэдээлэл хүргэж ажилласны үр дүнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 70 дугаар захирамжаар Үндэсний зөвлөл байгуулагдаж, энэ асуудлыг бодлогын түвшинд зангидах болсон. Түүнчлэн МУ-ын ҮАБЗ-ийн 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 19/15 дүгээр зөвлөмж гарсан. Мөн ХҮТ-ийн үр дүнгийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөөг Монгол Улсын ЗГ-ын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хурлаар хэлэлцэж баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хийгдээд явж байгаа боловч ХАЗ-ийн байгууллагууд зарим тохиолдолд хөрөнгө мөнгөний асуудал их гардаг. Энэ дээр л дэмжлэг авмаар байгаа юм.

Хяналтын байгууллагуудыг чадавхжуулах, мэдлэг мэдээллээр хангах, магадгүй бүтцийг нь сайжруулахад анхаарч байна уу?

ХАЗ-ийн байгууллагууд дотоод нөөц бололцоогоо ашиглан шаардлагатай бүтцийн зохион байгуулалтыг хийж байгааг хэлэхэд таатай байна. Байгууллагуудын удирдлагууд нөхцөл байдлыг сайн ойлгож, үүнд их дэмжлэг үзүүлж байна. Харин дээр хэлсэнчлэн холбогдох яамдууд санхүүгийн дэмжлэг үзүүлж, боловсон хүчний

мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, бүс нутгийн хуралд оролцох санхүүжүүлтийг нь шийдэж өгөх шаардлага үүсээд байна. Бүс нутгийн арга хэмжээнүүдэд оролцох нь нэн тэргүүнд Монгол Улс энэ асуудалд анхаарал хандуулж байгааг харуулна. Хоёрт, тухайн арга хэмжээнүүдэд оролцсон хүмүүс бусад орны шинжээчидтэй уулзаж, туршлага судалж, өөрийн ажилд хэрэгжүүлэх, бидэнд тулгамдаж байгаа асуудлыг шийдэх гарцыг олох боломж бүрдэх юм.

Эцэст нь, Монгол Улс "саарал" жагсаалтад орохгүйн тулд биднээс ямар нөхцөл байдлыг шаардаж байна вэ?

Одоо мөрдөгдөж байгаа МУТСТ тухай хуулийг ФАТФ-ын зөвлөмжид тусгагдсан шаардлагад аль болох нийцүүлэх. Холбогдох журам, зааврыг нийцүүлэн батлуулж, хэрэгжүүлэхэд анхаарах. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн боловсон хүчин бэлдэхэд техник тоног төхөөрөмжөөр хангах зэрэгт төр засаг анхаарах. Энэ байдал нь их зардалтай мэт харагдаж байгаа боловч уг ёсондоо ирээдүйдээ хийх хөрөнгө оруулалт шүү дээ.

Аливаа бохир мөнгөний ард хүний зовлон, зарим тохиолдолд амь байдгийг нийт иргэд ойлгож, энэхүү бохир мөнгөний урсгалыг илрүүлэхэд санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үйлчлүүлэхдээ шаардлагатай мэдээллийг үнэн зөвөөр өгч хэвших хэрэгтэй байна. Өөрөөр хэлвэл, төр иргэн хоёр хамтарч ажиллаж байж энэ асуудлыг шийднэ. Энэ бол Монгол Улсын эрх ашиг юм.

Баярлалаа.

МӨНГӨ УГААХ

- Татвараас нуун далдлах
- Залилан мэхлэх
- Өмч хөрөнгө завших
- Авлига, хээл хахууль өгөх



- Хар тамхи
- Буу, зэвсгийн наймаа
- Хулгай

ҮЕ ШАТ

#1

БАЙРШУУЛАХ



Танай банкинд "Жүржэн" компанийн нэр дээр \$1,000,000 данс нээлгэх хүсэлтэй байна.



Итгэл Банк



Шилжүүлэг

"Талстхан" компани руу \$500,000, "Алимхан" компани руу \$10,000 гэх мэт шилжүүлгүүд хийнэ.

#2

НУУН ДАЛДЛАХ



"Алимхан" компани руу шилжүүлэг



А Банк



В Банк



Санхүүгийн системд эргэлтэд оруулах



С Банк

"Талстхан" компани руу шилжүүлэг



Д Банк

#3

ТӨВЛӨРҮҮЛЭХ



Худалдаа болон үйлдвэрлэлийн салбарт \$500,000 хөрөнгө оруулалт хийх



Е Банк



Т Банк



Тансаг зэрэглэлийн хөрөнгө оруулалтад \$10,000 зарцуулах



МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООГ ХЭРХЭН САЙЖРУУЛАХ ВЭ?

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс манай улсад ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоогоо сайжруулах хугацаатай үүрэг өгсөний дагуу ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж, мөнгө угаахтай тэмцэх тогтолцоогоо сайжруулах зүй ёсны шаардлагын талаар Хамтын ажиллагааны зөвлөлд багтсан байгууллагуудаас дараах байр суурийг илэрхийлж байна.



ХЗДХЯ

Хэрэв манай улс “саарал” жагсаалтад орвол гадаад гүйлгээн дээр хязгаарлалт тавигдана гэсэн үг. Гадаад улс руу болон гадаад улсаас төлбөр тооцоогоо арилжааны банкаар дамжуулж хийх боломжгүй болно гэдэг нь эдийн засгийн хувьд хилээ хааж байгаагаас ялгаагүй үр дагавартай хор уршиг дагуулна. Бүхэлдээ банкны санхүүгийн систем зогсоно гэсэн үг. ФАТФ-аас сэжигтэй гүйлгээ, сэжигтэй борлуулалтын талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл өгөх үүрэг бүхий этгээдүүдийн хүрээ хязгаар хангалтгүй байна гэж үзэж байгаа. Зөвхөн банк, санхүүгийн байгууллагаар хязгаарлаж болохгүй гэсэн. Хуулийн зөвлөх, нотариатч, алт мөнгөний худалдаа хийдэг хүмүүсийг мэдээлэх үүрэг бүхий этгээдийн тоонд оруулах ёстой гэдэг шаардлага тавьсан. Энэ шаардлагыг хуулийн төсөлд тусгасан байгаа.



АТГ

-ФАТФ-ын зүгээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хууль сахиулах байгууллагуудын зүгээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа шинэ түвшинд гарах давуу тал бий болно. Төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд илэрсэн дутагдлыг засч залруулах, суурь гэмт хэргийг тогтооход чухал ач холбогдолтой. Түүнчлэн АТГ-ын хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хамаарах албан тушаалын байдлаа

урвуулах замаар олсон авлига, хээл хахуулийн мөнгөө гуравдагч улс орон руу шилжүүлж, эд материал болгох, эсхүл бэлнээр Монгол Улс руу оруулж ирэх байдлаар мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжиж байгаа этгээдүүдийн гэмт үйлдлийг илрүүлэх, саармагжуулах, урьдчилан сэргийлэх ажилд чухал түлхэц болно. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд манай байгууллагын хувьд эрх зүйн харилцан туслалцааны түвшинд бэрхшээл тулгарч байгаа. Мөн дотооддоо арилжааны банкуудтай харилцан мэдээлэл солилцох механизм учир дутагдалтай байгаа учраас нэгдсэн ойлголтгүй байх зэрэг хүндрэлүүд байсаар байна.



ЦЕГ

“Ази Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 3.2 дахь заалтад “Хууль сахиулах байгууллагуудад Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгж байгуулах, чадавхийг дээшлүүлэх” ажлыг Цагдаагийн байгууллага хариуцан ажиллахаар тусгагдсан. Энэ хүрээнд ЦЕГ-ын даргын 2018 оны 01 сарын 11-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар болгон өргөжүүлж, Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Мөрдөн шалгах хэлтсийг байгуулан ажиллуулж байна. Цаашид Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чадавхийг дээшлүүлэх, мөрдөн шалгаж байгаа мөнгө угаах, санхүүгийн гэмт хэргүүдэд санхүүгийн шинжилгээг тогтмол хийх зорилгоор санхүүгийн мэргэшсэн

шинжээчийн орон тоог шийдвэрлүүлэх боломжийг судалж байгаа. Мөн Цагдаагийн байгууллагаас мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий мөрдөгчдийг дотоод нөөц бололцоогоо ашиглан мэргэшүүлж сургах, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажлын үр дүнг дээшлүүлэх, гадаад улсын туршлагыг нэвтрүүлэх, Монголбанк болон холбогдох бусад байгууллагатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад анхаарч ажиллаж байна.



СЗХ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх ажиллагаатай тэмцэх тогтолцоо нь сул байгаа улс орнуудад бохир мөнгө ихээр орж ирдэг. Ингээд гэнэт их хэмжээний мөнгө орж ирэхэд санхүүгийн нөхцөл байдал нь сайжирч байгаа юм шиг харагддаг. Гэтэл тэр мөнгө, үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас нь тухайн улсад түр байршиж байна л гэсэн үг. Цаг нь болохоор зүсийг нь хувиргаад буцаагаад аваад явна. Тэр мөнгө, хөрөнгө, үнэт цаас нь зүсээ өөрчлөөд гэнэт гарахад тухайн орны эдийн засаг нь хүнд байдалд орж, сөрөг нөлөө үзүүлдэг. Дэлхий нийтээрээ терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажил эрчимжиж байгааг хүн болгон мэдэж байгаа. Дэлхий нийтээр нэг стандартаар, нэгэн зэрэг тэмцэхгүй бол үр дүнд хүрдэггүй учир FATF зөвлөмж гаргаад байгаа юм. FATF нь хар, саарал жагсаалтад орсон зарлахаас бус ямар нэгэн хориг тавьдаггүй. Хар, саарал жагсаалтад орсон нөхцөлд олон улсын банк, санхүүгийн байгууллагууд гүйлгээ хийхээс татгалзаж эхэлдэг. Хар жагсаалтад орсон улс орны бизнес эрхлэгчид болон иргэд гадаад улсад картаар мөнгөн гүйлгээ хийгдэх боломжгүй болно. Гадаадаас манай улс, манай улсаас гадаа улс руу гүйлгээ хийх зэрэгт тодорхойгүй хугацаагаар шалгаж удаадаг.

УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ



2018 ОН

1



Засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх, авлигалын эсрэг тууштай тэмцэх

2



Гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах

3



Төсвийн сахилгыг хангах, үндэсний хуримтлалтай болж, бодит эдийн засаг, инфляцийг тогтворжуулах

4



Эдийн засгийн дархлааг хангах хэмжээнд гадаад валютын нөөцийг хуримтлуулах, өрийн дарамтаас сэргийлэх



НАЙМАН ЗАРЧИМ

5



Хүчтэй санхүүгийн салбар, санхүүгийн зах зээлийг зохистой төвшинд либералчлах, өрсөлдөөн бий болгох

6



Аж үйлдвэржилтэд түүчээлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай компанийг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх

7



Дэлхийн болон бүс нутгийн дэд бүтцийн том хөтөлбөрүүдэд багтаж орох, орон нутгууд тэгш хөгжих боломж бүрдүүлэх

8



Байгалийн баялаг-аа оновчтой байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах, "Баялгийн хараал"-аас зайлс хийх

“УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ”-ИЙН 8 ЗАРЧИМ

Монголбанк эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн бодлогын жор болох учиртай “Улаанбаатарын зөвшилцөл”-ийн 8 зарчим " төслийг санаачлан эдийн засгийн бодлого шийдвэрийн суурь тунхаглал байхаар хэлэлцүүлж байгаа бөгөөд судлаач болон мэргэжлийнхний саналыг тусгасан бодлогын зарчмуудыг цувралаар танилцуулж байна. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад хамгийн түрүүнд засаглалын чадвар түүний тогтвортой байдал чухал суурь болох юм.

1. ЗАСАГЛАЛ, ИНСТИТУЦИЙГ САЙЖРУУЛЖ, ЧАНАРЫГ БЭХЖҮҮЛЭХ, АВЛИГАЛЫН ЭСРЭГ ТУУШТАЙ ТЭМЦЭХ

Агуулга, хамрах хүрээ: Засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх, авлигалын эсрэг тууштай тэмцэх зарчмын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

- Авлигалын эсрэг тууштай тэмцэх,
- Төрийн байгууллагуудын эрх, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох,
- Хэвлэл, мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, иргэдэд авлигалын хор уршгийн талаар цэгцтэй мэдээлэл өгөх,
- Хуулийг сахин биелүүлэх, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэж чаддаг болох,
- Засаглал, институцийн чанарыг бэхжүүлэх,
- Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бүх

шатны байгууллагын шинэтгэлийг түргэтгэж, тэдгээрийн авлигалтай тэмцэх болон түүнээс урьдчилан сэргийлэх үүргийг тодорхой болгон үйл ажиллагааг нь уялдуулах,

- Олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтран ажиллах.

Тус зарчмыг хэрэгжүүлэхэд дараах хүчин зүйлсэд тулгуурлана:

- Улс төрийн хүчнүүдийн хооронд болон төрийн эрх мэдлийн дээд шатны байгууллагуудын нэгдсэн хүсэл эрмэлзэл,
- Иргэд, олон нийтийн дэмжлэг, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх,
- Авлигалын эсрэг боловсронгуй хууль тогтоомж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох,
- Авлигалаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг тасралтгүй өрнүүлэх,

- Төрийн албан хаагчдын цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлэн, тэдний ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан тогтоож мөрдүүлэх.

Үндэслэл, шаардлага: Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт нь биет капиталын гүнзгийрэлт, хүмүүн капиталын хуримтлал, бүтээмжийн өсөлтөөр тодорхойлогдоно. Харин хуримтлал болон бүтээмжид нөлөөлөх чухал хүчин зүйл нь институц юм. Учир нь өмчийн эрх, зохистой зохицуулалтын бүтэц, шүүхийн бие даасан байдал, төрийн чадавх зэрэг нь эдийн засгийн өсөлтийг бий болгож, цаашид тогтвортой байлгахад туйлын чухал юм. Институц нь эдийн засаг өсөхийн хэрээр сайжирдаг гэсэн эхэн үеийн итгэл үнэмшил нь институц өөрөө өсөлтийн урьдчилсан нөхцөл, суурь тодорхойлогч гэсэн шинэ хандлага руу шилжиж байна.

Эдийн засгийн өсөлт нь худалдаа, институц, газар зүйн байршил зэрэг хүчин зүйлсийн үйлчлэлд нөлөөтэй байдаг. Тухайлбал, улс баян болохын хэрээр илүү их худалдаа хийж, илүү сайн чанартай институцийг бүрдүүлж болно. Acemoglu ба бусад (2001) нар институцийн чанар нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг чухал хүчин зүйл болохыг эмпирик түвшинд нотолсон байна.

Институцийн чанар бол эдийн засгийн өсөлтийн хамгийн чухал хүчин зүйл мөн. БНХАУ, Ботсван, Мавритани, Австрали зэрэг улсын сайн институц нь хуулийн хэрэгжилтийг хангах, зах зээл хөгжих, одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдын өмчийн эрхийг хамгаалах, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад хүргэсэн байна. Тэр дундаа Ботсван улсын хувьд очир алмазны орлогыг хамгийн сайн удирдаж хөгжсөн орон юм. Тухайлбал, төрийн үйлчилгээ нь үр ашигтай, төсвийн зохицуулалт нь тогтсон дүрмийн дагуу хийгддэг, боловсрол, эрүүл мэндийн салбар, дэд бүтцэд төсвийн их хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг, өрсөлдөх чадварыг хангах түвшинд валютын ханшийг байлгадаг байна.

Авлигал нь улс орнуудын хөгжилд саад тотгор учруулж, ардчилал, шинэчлэлийн явцыг сааруулах, үндэсний эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн үр ашгийг бууруулах хүчин зүйл болж байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, томоохон улс орон, нэр хүнд бүхий олон улсын байгууллага, улс төрчид түүний эсрэг тэмцэлд идэвхтэй оролцох боллоо.

Манай орны хувьд засаглал, институци бол онцгой анхаарах тулгамдсан асуудал болоод байна. Хүчтэй, сайн институци нь байгалийн баялгийн хараалаас зайлсхийж, тогтвортой өсөлтийг хангах боломжийг олгох бөгөөд үүнийг бүрдүүлэх нь авлигаас ангид, хуулийг ёсчлон хэрэгжүүлдэг, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрддөг төрийн байгууллага, албан хаагчдаас эхэлнэ.

Сайн институци бүрдсэн үед хэн тухайн ажлыг хийхээс үл хамааран тухайн байгууллагын гарах шийдвэр, арга хэмжээ нь цаг хугацааны хувьд харилцан нийцтэй байх учиртай. Харин сайн засаглал тогтсон үед хууль ёс бүрэн хэрэгжиж, үйл хөдлөл, шийдвэр бүрийн хойно хариуцлага дагалдах учиртай. Институц, засаглалын чанарыг сайжруулахгүйгээр манай улс төрийн бодлогоос үр дүн хүлээх, байгалийн баялгийн хараалыг тойрч гарахгүй.

Иймд Монгол улсын өнөөгийн нөхцөл байдлаас дүгнэхэд засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх, авлигалын эсрэг тууштай тэмцэх шаардлага тулгараад байна.

Сайн институцийг бүрдүүлэх боломжтой, гэхдээ энэ нь туршилт, уламжлалт байдлаас ангижрах хүсэл, мөн тухайн орны онцлогийг харгалзахыг шаарддаг байна. Бэрхшээлтэй цаг үед эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалахын тулд илүү хүчтэй институцтэй байх ёстой.

Хүлээгдэж буй үр дүн:

- Авлигалтай тэмцэх ажлын эрх зүйн орчныг шинэ нөхцөлд нийцүүлэх,
- Төр, засгийн байгууллагуудын засаглал, институцийн шинэтгэлийг түргэтгэх,
- Авлигалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын өөрийн орны онцлогт тохирсон шинэ загвар бий болгон хэрэгжүүлэх, авлигалыг сааруулж, түүнийг үл тэсвэрлэх уур амьсгалын эхлэл тавих,
- Авлигалтай холбоотой хэргийн илрүүлэлтийг сайжруулж, иргэд олон нийтийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх,
- Төр, иргэний хоорондын итгэлцлийг бэхжүүлэх чиглэлд мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гаргах тухай асуудал юм.

Үргэлжлэлийг дараагийн дугаараас ...

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ЭМЭЭЛИЙН ХАШ ЧУЛУУН ТОНОГ

XX зуун

Жин: 532 гр

Эмээлийн даруулга: 44.5х 44.5 мм, 4 ш

Баавар: 57.7х42.0 мм, 2 ш

Ганзаганы сүвэгч: 53.8х25.3 мм, 4 ш



Шашны болоод хэрэглээний эд зүйлст түгээмэл дүрслэгдэх дөрвөн дэлбээт цэцэг болон хамар угалз хээг ухаж сийлсэн хагас тунгалаг, цагаан өнгийн хаш чулуун эмээлийн чимэглэл

Монголчууд эмээлийн хэрэглэлийг ихэвчлэн ган болон мөнгөөр урладаг нь эдлэхэд бат бөх байдлыг харгалзсанаас үүдэлтэй бөгөөд хаш чулуугаар хийх нь ховор тохиолдоно. Монгол орны хувьд хатуулаг чулуу болох цагаан хаш нь ховор, харин хар ногоон өнгийн хашны илэрц Хөвсгөлийн уулс орчмоор байдаг байна. Тиймээс 1911 онд хааны хас эрдэнийн тамгыг хийсэн ховор үнэт, цагаан хаш чулууг олж авчирсан хүнийг зарлигаар хөхүүлэн шагнасан түүхтэй. Энэхүү эмээлийн цагаа хаш тоног нь баавар, даруулга, ганзаганы сүвэгч, ганзаганы даруулга зэргээс бүрдэнэ.

МОНГОЛБАНК

Монголбанк юу хийдэг вэ?

“Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд зааснаар”
өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах
чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ.

Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх



Монголбанк төрийн мөнгөний бодлогыг
боловсруулж, хэрэгжүүлнэ.



Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн
мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10
дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн
барина.



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах



Мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх,
хадгалах, түүний нөөцийг бий болгох, хүчин төгөлдөр
эсэхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах
ажлыг эрхлэн зохион байгуулна.



Гэмтэж муудсан мөнгөн тэмдэгт солих журмыг
Монголбанк тогтооно.

Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх



Төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын
хүсэлтээр өөр дээрээ байршуулж, гүйлгээг хийнэ.



Засгийн газрын хүсэлтээр Засгийн газрын үнэт
цаасыг бусад этгээдэд зуучлан борлуулна.



Хууль тогтоомжид нийцсэн зуучлалын бусад үйл
ажиллагаа эрхэлнэ.



Банк болон хуульд тугайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих



Банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх
зорилгоор банк байгуулах зөвшөөрөл банкинд олгоно.



Үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм,
журам шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.



Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл
ажиллагаанд хяналт тавина.

Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах



Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкин дахь
тухайн банкны харилцах дансаар дамжуулан
гүйцэтгэнэ.



Үндэсний төлбөрийн систем, түүний үйл
ажиллагаанд холбогдсон харилцааг Үндэсний
төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна.



Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах



Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад
валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн
гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангана.



Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй
адилтгах хэрэгслийг төгрөгөөр худалдах, худалдаж
авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана.

Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах



Зохистой харьцааг хангуулах хяналт шалгалтыг
хэрэглэгчийг хамгаалах хяналттай хослуулна.



Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах "Их 20"-ын 11
зарчмыг нэвтрүүлнэ.



Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг
дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



Макро зохистой бодлого хэрэгжүүлэх



Мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк,
санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан
сэргийлэх зорилгоор тус бодлогыг боловсруулна.



Макро зохистой бодлогыг заавал байлгах нөөц зэрэг
хэрэгслүүдээс ашиглан хэрэгжүүлнэ.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРГАЛТАД МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ

Монголбанк юу хийдэг вэ? булангаар энэ удаа Мөнгөний бодлогын газрын үйл ажиллагаатай танилцуулж байна. Тус газрын Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн ахлах эдийн засагч Ч.Алтан-Өлзийгөөс энэ талаар тодрууллаа.

Завгүй ажиллаж байна уу, өнөөдөр таны хувьд хэр ачаалалтай ажиллаж байна вэ?

Өнөөдөр миний хувьд энгийн л нэг ажлын өдөр үргэлжилж байна. Миний ажлын өдөр өглөө ирээд и-мэйлээ шалгаж, шаардлагатай захидлуудад хариу илгээхээс эхэлдэг. Ажлын хувьд бага зэрэг ачаалал ихтэй байгаа. Бид удахгүй Динамик Стохастик Ерөнхий Тэнцвэрийн (DSGE) загвар хөгжүүлэх төсөл эхлүүлэхээр бэлтгэл ажлаа хангаад явж байна. Үүний хүрээнд өмнө нь энэ чиглэлийн хүрээнд хийгдэж байсан ажлуудаа эргэн сөхөх, бусад шаардлагатай материалуудыг бэлтгэх, мөн багагүй тоо бодох ажлуудыг яг одоо хийж байна.

Танай газар мөнгөний бодлогын шийдвэр гаргахад нөлөөлдөг бодлогын чухал газар шүү дээ. Ажлынхаа чиг үүргийн талаар сонирхуулна уу?

Мэдээж, төв банкны үндсэн зорилт болох нам, тогтвортой инфляцийн зорилтыг хангахад чиглэдэг. Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай бодлогын шинжилгээ, төсөөллийг улирал бүр болон тухай бүр гүйцэтгэх,

макро эдийн засгийн эрсдэл, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө, бодлогын боломжит хувилбаруудын нөлөөллийн тооцоолол дээр үндэслэн бодлогын саналыг боловсруулж Мөнгөний бодлогын зөвлөлд танилцуулах үндсэн үүрэгтэй. Үүнээс гадна бодлогын шинжилгээнд шаардлагатай тооцооллыг хийхэд ашиглагдах макро эдийн эдийн засгийн болон бусад загваруудыг хөгжүүлдэг. Түүнчлэн мөнгөний бодлогын сувгийн үр ашигтай байдал, нөлөөллийг шинжлэх, Төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг боловсруулах чиг үүрэгтэй.

Танай газраас гаргадаг мэдээлэл олон нийтэд хэрхэн хүрдэг вэ?

Бид 2015 оноос эхлэн Инфляцийн төлөв байдлын тайланг улирал болгон гаргаж, олон нийтэд хүргэж байгаа. Уг тайлангаар макро эдийн засгийн сектор тус бүрт дүн шинжилгээ хийж, ойрын ирээдүйн төлөв хэрхэх, дунд хугацаанд ямар эрсдэл, тодорхой бус байдал бидэнд байна вэ гэдгийг олон нийтэд хүргэдгээрээ давуу талтай. Монголбанкнаас Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн тооцоо судалгаа, жилийн тайлан зэрэг олон хэвлэмэл

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ГАЗАР

Үндсэн үүрэг



Макро эдийн засгийн тогтвортой байдал, дотоод үнийн тогтвортой байдлыг хангах хүрээнд

1



Эдийн засгийн шинжилгээ хийх

2



Мөнгөний болон макро зохистой боловсруулах

Чиг үүрэг



Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтэс

1. Мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулах, хэрэгжилтийг хангах;
2. Гадаад валютын ханшийн талаар баримтлах бодлогыг боловсруулах;
3. Эдийн засгийн ирээдүйн төлөв, түүнийг илтгэх гол үзүүлэлтүүдийн төсөөлөл, бодлогын шинжилгээнд үндэслэн мөнгөний бодлогын талаар авах арга хэмжээний саналыг боловсруулж, танилцуулах;
4. Эдийн засгийн судалгаа, шинжилгээ, төсөөлөл хийхэд ашиглагдах загваруудыг сайжруулах, шинээр хөгжүүлэх;
5. Мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс бодлогын шийдвэр, арга хэмжээг олон нийтэд тайлбарлаж хүргэх;
6. Төрийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн бодлогын баримт бичигт санал өгөх;
7. Макро зохистой бодлогын шинжилгээг хийж, бодлогын санал боловсруулах;
8. Мөнгөний бодлогынхэрэгжих болон үйл ажиллагааны хүрээнд шинжилгээ хийх, санал боловсруулах.



Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтэс

1. Инфляцийн гүйцэтгэл, ойрын төлөвийн шинжилгээ хийх;
2. Бодит сектор (эдийн засгийн салбарын болон эрэлтийн)-ын шинжилгээ хийх;
3. Гадаад секторын (төлбөрийн тэнцэл, экспорт-импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний эрэлт/үнэ, гадаад эрэлт) шинжилгээ хийх;
4. Банк, санхүүгийн зах зээл, мөнгөний захын судалгаа шинжилгээ хийх;
5. Гадаад валютын ханшид нөлөөлсөн хүчин зүйлсийн судалгаа, шинжилгээг хийх;
6. Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн богино хугацааны болон тухайн улирлын төсөөлөл, шинжилгээ хийх.

бүтээгдэхүүнийг эрхлэн гаргадаг. Уг бүтээгдэхүүн тус бүр эдийн засгийн шинжилгээ, тооцоо, судалгааг тодорхой хэмжээнд агуулсан байдаг. Харин Инфляцийн төлөв байдлын тайланд нэгдүгээрт эдийн засгийн сектор тус бүрт нарийвчилсан шинжилгээ хийгддэг, хоёрдугаарт дотоод болон гадаад эдийн засгийн цаашдын төлөвийг тодорхойлж, учирч болох эрсдэл болон тодорхой бус байдлыг дэлгэрэнгүй авч үздэг, гуравдугаарт улирлын давтамжтай, монгол болон англи хэл дээр гардгаараа давуу талтай.

Энэ мэдээллийг ашиглах нь ямар ач холбогдолтойг тайлбарлана уу?

Төв банкны зорих ёстой нэг зүйл нь эдийн засагт оролцож байгаа агентуудын хүлээлтийг удирдах. Тэгэхээр, инфляцийн төлөв байдлын тайлангаас иргэд болон аж ахуйн нэгжүүд эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлын талаар үнэн бодитой, зөв мэдээлэл, мэргэжлийн чанартай шинжилгээ, тооцоолол авах боломжтой байдаг. Мөн өөр ямар эрсдэл байна вэ гэх мэт мэдээллийг авсанаар эдийн засгийн харилцаанд оролцох шийдвэр гаргалтандаа ашиглах боломж үүснэ. Зөвхөн манай улсын иргэд, аж ахуйн нэгжүүд гэлтгүй гадны байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулагчид ч мөн англи хэл дээрх хувилбараас дэлгэрэнгүй мэдээлэл авч ашиглах боломж нээлттэй.

Инфляцийн төлөв байдлын тайланг дэлхийн олон улсын төв банкууд олон жилийн турш тогтмол

боловсруулж, олон нийтэд хүргэсээр ирсэн ба энэ нь мөнгөний бодлогын нэг хэрэгсэл болтлоо хөгжөөд байгаа. Манай улсын хувьд уг тайланг хэрэглээнд нэвтрүүлээд их хугацаа өнгөрөөгүй ч алхам тутамдаа тайлангийн бүтэц, шинжилгээг сайжруулсаар байна. Нөгөөтэйгүүр бид инфляцийн төлөв байдлын тайлангийн шинжилгээнд ашиглагдсан тоон үзүүлэлтүүдээ вэб сайт дээрээ тавьдаг болсон. Энэ нь гадаадын төв банкуудын хувьд дэлгэрч байгаа бас нэг соёл болж байгаа. Тэгэхээр бид тоон өгөгдлийн хувьд илүү нээлттэй болж, эрдэмтэн, судлаачид, оюутнууд энэ тоон өгөгдлүүдийг чөлөөтэй авч судалгаа, шинжилгээндээ ашиглах боломжтой гэсэн үг.

Танай хэлтсийн хувьд үүнд ямар шинэлэг загвар дээр ажиллаж байгаа талаараа сонирхуулна уу?

Манай хэлтсийн нэг чиг үүрэг нь макро эдийн засгийн дүн шинжилгээ, төсөөлөл хийхэд ашиглах загваруудыг хөгжүүлэх, сайжруулах тал дээр ажилладаг. Бид 2012 оноос эхлэн төсөөлөл, бодлогын шинжилгээний системийг нэвтрүүлж, бодлогын шийдвэр гаргалтандаа ашиглаж байгаа. Тэрхүү системийг илүү боловсронгуй, өргөн цар хүрээтэй болгохын тулд бид ажиллаж байна. Мөн инфляци болон дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөлөл хийх загварууд дээр түлхүү ажилладаг. Дэлгэрүүлээд хэлбэл, төв банк макро эдийн засгийн загварчлалд ашиглах техникийнхээ хувьд дэлхийн түвшинтэй аль болох хөл нийлүүлж алхах нь

зүйтэй. Бидний хувьд хамгийн сүүлд хүчин зүйлсийн (factor models) загваруудыг хөгжүүлж макро эдийн засгийн богино хугацааны төсөөлөлд нэвтрүүлж эхлээд байна. Уг загваруудын гол санаа нь их хэмжээний тоон өгөгдөл дундаас хувьсагчдын ерөнхий хөдөлгөөнийг харуулах ажиглагдаагүй хувьсагч (фактор) үүсгэж авах, үүнийг шинжилгээ, төсөөлөлдөө ашиглах юм. Одоогийн байдлаар 120 гаруй хувьсагч бүхий тоон өгөгдлийг ашиглаж байна.

Макро эдийн засгийн төсөөлөл нь мөнгөний бодлогын шийдвэр гаргалтанд хэр чухал нөлөөтэй вэ?

Мөнгөний бодлогын аливаа шийдвэр гаргалт нь нийгэм, эдийн засгийн ирээдүйн төлөвийн нэгэн түүчээ нь болдог. Үүн дотроо макро эдийн засгийн төсөөлөл сайн хийгдэж байж, мөнгөний бодлогын зөв шийдвэр гарах суурь нөхцөл нь бүрддэг. Энэ утгаараа макро эдийн засгийн төсөөлөл гэдэг зүйл маш чухал юм. Мөнгөний бодлогын шийдвэр нь ард иргэдийн өдөр тутмын амьдралд магадгүй таны бодож буйгаас ч илүү чухал нөлөөтэй. Тодруулбал, мөнгөний бодлогоор дамжин зах зээлд, гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон банкны хүү зэрэг тодорхойлогддог. Мөн үнийн тогтвортой байдал хангагдсанаар иргэдийн худалдан авах чадварыг хамгаалж чадна.

Таны хувьд макро эдийн засгийн төсөөллийг хийхэд хэрхэн оролцог вэ?

Миний хувьд загварыг хөгжүүлэх, сайжруулах чиглэлд түлхүү ажилладаг. Энэ утгаараа илүү загварын тавил, математик гаргалгаа, эдийн засгийн загварчлалын програм дээрх код дээр ихэвчлэн ажилладаг. Ингээд загвараа боловсруулж, тодорхойлсоны дараа тоон өгөгдлүүдтэйгээ ажиллаж эхэлнэ. Тоон өгөгдлүүдээ оруулаад, Монголын нөхцөлд уг загвар хэр ажиллаж байна вэ, манай нөхцөл байдалтай хэр зохицож байна вэ гэдгийг шалгадаг. Ингэхдээ түүхэн тоон өгөгдлүүдээ оруулаад хугацааны өнгөрсөн үеүдэд уг загвар хэр ажиллахаар байсан бэ гэдгийг шалгана гэсэн үг юм. Энгийнээр хэлбэл бидний гүйцэтгэсэн төсөөлөл бодит байдалтай хамгийн ойр, алдаа багатай байх загварыг л эрэлхийлдэг юм.

Мэдээж төв банкуудын хувьд өчнөөн олон загвар байдаг. Нэг загвараараа төсөөллөө гаргалаа гэхэд бусд загваруудаа ч бас давхар шалгаад л явдаг. Ингээд хооронд нь харьцуулах маягаар ажилладаг. Мөнгөний бодлогын газар ч мөн эдийн засгийн богино хугацааны төсөөллийн тал дээр хэд хэдэн загвартай болчихсон, зэрэг ашиглаад явж байна. Загвар тус бүр дээр төсөөлөл хийх чадварыг нь сайжруулаад явдаг. Бидний дараагийн зорилт бол эдгээр ашиглагдаж буй

загваруудаа нэгтгээд нэг систем-загвар болгохоор ажиллаж байна. Ингэхдээ илүү хялбар замаар, цөөн алхамын дараагаар загвар тус бүрийн үр дүнг гаргах, түүнчлэн олон улсын сүүлийн үеийн чиг хандлага болох макро эдийн засгийн загваруудын үр дүнг дундажлах арга техникуудийг уг системд нэвтрүүлэхийг зорьж байна.

Мөнгөний бодлогын газрын хамт олон бол харьцангуй залуу, эрч хүчтэй боловсон хүчин бий. Хэдий олон янзын загвар гаргаад шинэчилж, сайжруулаад явдаг ч сурч боловсрох, хөгжих шаардлага их. Тиймээс дэлхий нийтийн макро эдийн засгийн загварчлалын шинэчлэл, хурдацтай хөгжлөөс аль болох хоцролгүйгээр өөрсдийгөө хөгжүүлэх, сайжруулахыг хичээдэг. Тиймээс бид сар бүр энэ чиглэлийн лекц, семинар зохион байгуулж, үүнийг уламжлал, соёл болгохоор ажиллаж байна. Ингэхдээ Монголбанкны болон гадны багш, эрдэмтдийг урьж, орчин үеийн загварчлалын техник, чиг хандлагын талаар ярилцаад, суралцаад явдаг.

Манай улсын хувьд макро эдийн засгийн төсөөлөл хийхэд хүндрэлтэй зүйлс юу вэ?

Манай улсын эдийн засаг хэлбэлзэл, савалгаа өндөртэй. Эдийн засаг өслөө гэхэд богино хугацааны дараа эргээд унах, эсвэл унаж байгаад огцом өсөх ч юм уу. Тэр эргэлтийн цэгийн хугацааг таамаглах нь одоогийн нөхцөл байдалд хамгийн хүндрэлтэй асуудлуудын нэг болчихоод байгаа. Тэгэхээр бид эргэлтийн цэгүүдийг таамаглах тал дээр тодорхой ажлууд хийдэг. Гадны өндөр хөгжсөн орнуудын эдийн засгийн загварчлалын хувьд харьцангуй тогтвортой эдийн засгийн орчинтой. Манай улс шиг хөгжиж буй, савалгаа ихтэй эдийн засагтай орны хувьд нөхцөл байдал харьцангуй өөр. Энэ нөхцөлд олон төрлийн загварыг туршиж, хамгийн сайн төсөөлөл гүйцэтгэх загварыг гаргаж авах нь бидний хамгийн том сорилт юм.

- Ийм өндөр хариуцлагатай ажил хийж байгаа хүмүүст цагийн нарийн төлөвлөлт маш чухал байх тийм үү?

Төвбанкны ажилтны хувьд үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, өөрт оногдсон ажлаа цаг тухай бүрт нь чанартай хийхийг эрхэмлэдэг. Тиймээс ажлаа сайтар төлөвлөх хэрэгтэй болдог. Би хийж буй ажил бүрээ нарийн, жижиг дэд ажлуудад хувааж төлөвлөдөг. Үүнийг wunderlist аппликэшн ашиглаж, хөтөлж, төлөвлөдөг. Хийсэн ажлаа тэмдэглээд, хийх ёстой ажлаа хянаж байхад их амар байдаг юм.

Ярилцсанд баярлалаа.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... /2018.03.23/

Мөнгөний бодлогын зөвлөл 2018 оны гуравдугаар сарын 23-ны өдөр хуралдаж, Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэлээ. Мөн төгрөгийн заавал байлгах нөөцийг 10.5 хувь, валютын заавал байлгах нөөцийг 12 хувь байлгах шийдвэр гаргасан. Бодлогын хүү болон заавал байлгах нөөцийн хувь хэмжээг ийнхүү бууруулсан нь эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, банкнаас аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн өсөлтийг дэмжих шийдвэр болж байна. Бодлогын шийдвэрийг зарлах хэвлэлийн бага хурлын үеэр сэтгүүлчид дараах асуултуудад хариулт авсан юм.

Монгол ТВ: Бодлогын хүүг бууруулах энэ удаагийн шийдвэрийг гаргахад үндэслэсэн хамгийн гол хүчин зүйл юу байсан бэ?

МБГ-ын захирал Б.Баярдаваа:

-Мөнгөний бодлогын шийдвэрийг гаргахад гол үндэслэл нь инфляцийн төсөөлөл байлаа. Өөрөөр хэлбэл, 2018-2019 онд инфляци Төв банкны зорилтот төвшинд хадгалагдана гэх хүлээлттэй байна. Тийм учраас эдийн засгийн бодит секторын идэвхжлийг тодорхой түвшинд дэмжих нь зүйтэй гэж үзээд, бодлогын хүүг буурууллаа. Бодлогын хүүг бууруулснаар банкны салбарын эх үүсвэрийн өртөг буурна. Дагаад эдийн засагт гарч буй зээлийн хүү буурах үр дүн хүлээгдэж байна.

ETV: Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5 хувь болгосон гэж байна. Үүнийг тайлбарлана уу?

МБГ-ын захирал Б.Баярдаваа:

-Энэ удаагийн бодлогын шийдвэрийн нэг онцлог нь бодлогын хүүнээс гадна заавал байлгах нөөц дээр

шийдвэр гарсан. Монголбанк 2016 оны сүүлээс эдийн засаг дахь долларжилтыг бууруулахад анхаарал хандуулж ажилласан. Ингэснээр эдийн засгийн бодит секторын эрсдэл даах чадвар, мөнгөний бодлогын үр нөлөө сайжирна гэж үзэж байгаа. Энэ хүрээнд гарч байгаа хамгийн анхны шийдвэр нь төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулсан явдал болж байна. Тэгэхээр Төв банкны зүгээс арилжааны банкны доллараас илүүтэй төгрөгийн эх үүсвэр татах хандлагыг урамшуулж байна. Төгрөгийн эх үүсвэр нэмэгдсэнээр эдийн засаг руу төгрөгөөр гарах зээлийн хувь хэмжээ нэмэгдэх, долларжилт буурах, эдийн засгийн эрсдэл даах чадвар нэмэгдэж, гадаад эдийн засгийн шоконд өртөх эмзэг байдал буурах юм.

Блүүмбэрг ТВ: Инфляци эхний хоёр сарын байдлаар 6.9 хувьтай байна. Цаашдаа Монголбанкны зорилтот төвшнөөс давж болзошгүй байгаа үед бодлогын хүүг хэвээр хадгалах болов уу гэж ихэнх эдийн засагчид үзэж байсан. Харин

МБЗ бодлогын хүүг бууруулах шийдвэр гаргалаа. Тэгэхээр бодлогын хүүг бууруулах цаг, нөхцөл нь мөн үү?

-Мөнгөний бодлогын зөвлөлийн хурлын үеэр бодлогын хүүг хэвээр хадгалах хувилбар яригдсан. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын инфляци 8.1, улсын инфляци 6.9 хувьтай байна. Дунд хугацаанд инфляцийг 8 орчим хувьд тогтворжуулна гэсэн Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн зорилт бий. Хэдийгээр инфляци оны эхний хоёр сарын байдлаар харьцангуй өндөр байгаа ч үүнд нөлөөлж буй хэд хэдэн хүчин зүйл байгааг харгалзан үзсэн. Нэгдүгээрт, инфляцийн сагс шинэчлэгдсэнтэй холбоотойгоор зарим нэр, төрлийн барааны бүтцийн шинж чанартай өөрчлөлт байгаа. Энэ нь Улаанбаатар хотын хэмжээнд буй 8.1 хувийн инфляцийн 1.1 хувийг дангаар бүрдүүлж байна. Хоёрдугаарт, улирлын шинж чанартай холбоотойгоор нүүрс болон ахуйн түлшний үнэ өссөн нь нийт инфляцийн 1.4-1.5 хувийг бүрдүүлсэн. Энэ хоёр төрлийн барааг хасаад үзэхэд инфляци 5-6 хувьтай байхаар харагдаж байгаа. Энэ утгаараа инфляци бидний зорилтот төвшнөөс давах эрсдэл бага байна гэж дүгнэсэн.

МБЗ-ийн хараат бус гишүүн Б.Эрдэнэбат:

-Нэмж хэлэхэд, та бүхний мэдэж байгаачлан ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудад хийсэн активын чанарын үнэлгээний үр дүн эерэг гарсан. Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд энэ бол эерэг мэдээ. Мөн олон улсын зэрэглэл тогтоох байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг эерэгээр үнэлж байна. Ийм нөхцөлд гадаадаас их хэмжээний эх үүсвэр орж ирж, төгрөгийн ханшийг чангаруулах сөрөг нөлөөтэй байж болзошгүй. Үүнээс сэргийлэх нэг арга нь зээлийн хүүгийн түвшинг бууруулах юм. Тийм учраас бодлогын хүүгийн төвшинг бууруулсан гэж ойлгож байгаа. Энэ нь мөн эдийн засгийг долларжилтаас хамгаалах, урьдчилсан арга хэмжээ юм. Судлаачийн хувьд хэлэхэд, бид нийт зээл олголтыг авч үзвэл иргэдийн зээлийн хэмжээ байнга өсөн нэмэгдэж байгаа. Харин аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа зээлийн хэмжээ харьцангуй тогтвортой, сүүлийн 4 улирлыг харвал маш хангалтгүй өсөлттэй байна. Тэгэхээр бодлогын хүүг бууруулсан нь аж ахуйн

нэгжүүдэд олгогдох зээлийн эх үүсвэрийг хямдруулах алхам юм.

VTV: 2017 оны мөнгөний бодлого эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулахыг зорьж байсан. Харин энэ онд мөнгөний бодлогын хүрээнд ямар чиглэлийг баримталж байна вэ?

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг:

-Өнгөрсөн онд Монголбанк Засгийн газартай хамтран Засгийн газрын богино хугацаат өр төлбөрүүдийг нааштайгаар шийдсэн. Хөтөлбөр авсны үндсэн шалтгаан нь нэгдүгээрт, төсвийн тогтвортой байдлыг хангах юм. Төсвийн тогтвортой байдлын тухай ярихаар өрийн тогтвортой байдлын асуудал гарцаагүй хөндөгддөг. Тэгэхээр төсөв талдаа өрийн тогтвортой байдлын асуудал дунд хугацаанд нааштайгаар шийдэгдэхээр байна. Нөгөө талаас Монголын эдийн засаг түүхий эдийн экспортод түшиглэсэн бүтэцтэй. Энэ утгаараа түүхий эдийн үнийн өөрчлөлт эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлдэг. Дэлхийн түүхий эдийн үнийн цаашдын төсөөллийг харвал манай экспортын бүтээгдэхүүний үнэ дунд хугацаандаа харьцангуй тогтвортой байх дүр зураг харагдаж байна. Мэдээж богино хугацаандаа тодорхой хөдөлгөөнүүд гарна. Гэхдээ дунд хугацааны зэс, нүүрс, алтны хувьд эерэг байна. Энэ бүгдийг харж, тооцоолсны үндсэн дээр мөнгөний бодлогын шийдвэрийг гаргасан.

Роял ТВ: Гадаад валютын улсын нөөц одоогоор хэдэн тэрбум ам.долларт хүрээд байна вэ?

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг:

-Гадаад валютын улсын нөөц 2.9 тэрбум ам.долларт тэнцэж байна. Оны эцсээр манай гадаад валютын нөөц 3.1 тэрбум ам.долларт хүрсэн. Харин нэгдүгээр сард гадаад өр төлбөр төлөгдсөнөөр нөөц эргээд 2.9 тэрбум ам.доллар болсон байгаа.

25 ТВ: Гадаад валютын нөөцийн ихэнх нь өр, зээл гэж ярьж байгаа шүү дээ. Хятадын Ардын банкны своп гэх мэтчилэн. Валютын нөөц өссөн үр дүнтэй харагдаж байгаа ч цэвэр нөөц яг хэд байна вэ?

-Бид Хятадын төв банктай своп хэлцэл байгуулсан. Хэлэлцээрийн хүрээнд нарийн тоонуудаа хоёр төв банк гуравдагч этгээдэд хуваалцахгүй гэж тохирсон

байгаа. Ерөнхий динамикийг харвал цэвэр дүн намайг ажилд томилогдсон 2016 оны сүүл үеэс бараг 3 дахин сайжирсан гэдгийг хэлье.

25 ТВ: Банкуудад хийсэн активын чанарын үнэлгээ сайн гарсан. Гэхдээ чанаргүй зээл өссөн байгаа нь банкууд цаашдаа эрсдэлд орох вий гэх болгоомжлолыг бий болгож байна?

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг:

-Активын чанарын үнэлгээ сайн гарсан гэдэг үгийг хэлэх нь хэр зохимжтой юм бол. Би бол санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй үр дүн гарсан гэж тодорхойлно. Та бүхэн ч бас ингэж хэлэх хэрэгтэй байх. Монголбанкнаас активын чанарын үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн. Түүгээр 2017 оны жилийн эцсээр тохируулга хийгдсэн дүн нь ДНБ-ий 1.9 хувьтай тэнцэх өөрийн хөрөнгийн дутагдал гарсан. Тэгэхээр бидний зүгээс өөрийн хөрөнгийн дутагдлыг банкны системийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдэх боломжтой гэж үзэж байгаа. Өнөөдрийн байдлаар бид арилжааны банкуудаас ирүүлсэн ирэх 3 жилийн бизнес төлөвлөгөөтэй нь танилцаад байж байна. Цаашдаа өөрийн хөрөнгийн дутагдлыг яаж нөхөх, үйл ажиллагаагаа хэрхэн сайжруулах вэ гэдэг дээр бид ажиллаад явна. Активын чанарын үнэлгээний үр дүнгээр олон улсын үнэлгээний компаниас олон зөвлөмж өгсөн. Тэр дагуу Монголбанк арилжааны банкуудтайгаа ажиллаж байгаа. Чанаргүй зээлийн хувьд 2008-2009 оны хямралын үеэр чанаргүй зээлийн дүн банкны системийн нийт активын 17 хувьтай тэнцэж байсан. Өнөөдрийн байдлаар 7.8 хувьтай, хугацаа хэтэрсэн зээл 7.9 хувьтай байна. Монголын эдийн засаг уул уурхайгаас хамааралтай, хөрөнгийн урсгалын савалгаа ихтэй гэдгийг би дээр дурдсан. Үүнтэй холбоотойгоор тухайн салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дарамт, хүндрэл учрах тохиолдол бий. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээлийн тоонууд нь үүнийг л илэрхийлж байгаа юм.

Үндэсний шуудан: Зээлийн хүүг бууруулах талаар Монголбанк эхний алхмыг хийсэн. Цаашдаа хүүг бууруулах чиглэлд хэрхэн ажиллах вэ?

Судалгаа, статистикийн газрын захирал Д.Ган-Очир:

-Монголбанкин дээр зээлийн хүүг бууруулах стратегийг боловсруулах ажлын хэсэг гарч, зургаан

сарын хугацаанд ажилласан. Гуравдугаар сарын 20-ны өдөр ажлын хэсэг судалгааны үр дүнгээ олон нийт, судлаач, эрдэмтдэд танилцуулж, тэдний саналыг авсан. Өчигдөр буюу Пүрэв /03.22/ гарагт Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар энэхүү стратегийг авч хэлэлцсэн. Улмаар Монголбанкны төвшинд боловсруулагдсан тул сайшаагдсан байгаа. Харин одоо бусад төрийн байгууллагууд болох Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд энэ бичиг баримтаа хүргүүлж, санал зөвлөмжийг тусгана. Учир нь Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг батлах УИХ-ын тогтоолд “Зээлийн хүүг бууруулах стратегийг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран боловсруулах” гэж тусгасан. Тиймээс бусад оролцогч талуудынхаа санал, зөвлөмжийг авч тусгасны дараа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар эцэслэн баталж, олон нийтэд хүргэхээр ажиллаж байна. Энэ стратегийн баримт бичигт зээлийн хүүг бууруулахад чиглэгдсэн богино болон урт хугацааны зорилтуудыг тусгасан. Тухайлбал, богино хугацаанд төв банкнаас урт хугацаатай санхүүжилтийн хэрэгслийг бий болгоё. Үүгээрээ дамжуулаад хадгаламжийн зах зээл дээр бий болсон төвлөрөл, хүүний өрсөлдөөнийг бууруулах зэрэг ажлууд хийгдэнэ. Мөн зээлийн батлан даалтын сан, зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг шинэчлэх зэрэг томоохон зорилтууд ч бий.

ETV: Бодлогын хүү 10 хувь болж буурч байна. Энэ өөрчлөлт төсөвтэй хэр уялдаж байна вэ?

ССГ-ын захирал Д.Ган-Очир:

-Мөнгөний бодлогын зөвлөлийн хурлаар бид эдийн засгийн бүх секторуудыг авч үздэг. Монголын эдийн засагт өнгөрсөн хугацаанд нөлөөлж байсан гол хүчин зүйл нь үндсэндээ төсвийн хэт тэлэлтүүд. Үүнээс үүдэлтэй инфляци өсч, ханш сулардаг, улмаар бодлогын хүү өндөр түвшинд хадгалагддаг уялдаагүй бодлого хэрэгждэг байсан. Харин одоо ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд төсвийн сахилга бат дээшилж байгаа. Мөн төсвийн алдагдал ч бас шат дараатайгаар буурч байна. Тэгэхээр төсвийн зүгээс инфляцийг өсгөх, эдийн засгийн халалтыг бий болгох сөрөг нөлөөлөл энэ онд төдийлөн харагдахгүй байна гэдгийг судалгаа, шинжилгээ харуулсан. Энэ утгаараа төсөв, мөнгөний бодлогын уялдаа өнөөдрийн түвшинд хадгалагдаж байна.



ГҮЮГ ХААН 1206–1248



ГҮЮГ ХААНЫ МӨНГӨН ЗООС 1246–1249 ОН

Жин: 3.2 гр

Голч: 1.9 см

Нүүр тал "ОРД" гэж Монгол бичгээр бичсэн.
Холбоо онги тамгатай.

Ар тал: "Их орд" гэж арабаар бичсэн.



ГҮЮГ ХААНЫ МӨНГӨН ЗООС 1246–1249 ОН

Хархорум

Жин: 3,2 гр

Голч: 1.9 см

Нүүр тал: "Орд" гэж Монгол бичгээр
бичсэн. Холбоо онги тамгатай.

Ар тал: "Их орд" гэж арабаар бичсэн.

The image shows a close-up of the FATF (Financial Action Task Force) logo, which consists of the letters 'FATF' in a stylized font above a stylized eye. The logo is mounted on a building facade. The text 'FATF' is repeated in large, three-dimensional letters on the building's exterior.

МОНГОЛ УЛС 2018 ОНЫ 10 САР ГЭХЭД БИЕЛҮҮЛЭХ ХҮНДХЭН ДААЛГАВРЫГ АВААД БАЙНА

Х.Батчулуун

Дэлхий глобалчлагдан, улс орнуудын эдийн засаг харилцан хамааралтай болохын хэрээр зөвхөн нэг улсын хэмжээнд яригддаг байсан асуудлууд илүү өргөн хүрээнд хэлэлцэгдэж, гарах шийдвэр, хэм хэмжээ нь ч олон улсыг хамардаг болоод байна. Үүний нэгэн адилаар Монгол Улс нь Олон Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандартыг мөрдлөг болгох шаардлага тулгараад байгаа аж. Энэхүү нийтлэлийн гол зорилго нь мөнгө угаах, терроризмийн санхүүжүүлэхтэй холбоотой ойлголтууд, стандарт, Монгол Улсад хийгдээд байгаа ажлууд, цаашид үүсч болзошгүй эрсдэлүүдийг тайлбарлахад чиглэлээ.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай ойлголт

Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх гэдэг нь ерөнхий утгаараа аливаа гэмт хэргээс олсон мөнгөө өөр хэлбэрт шилжүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулж, гарал үүслийг нь дарагдуулахыг хэлж байгаа гэмт үйл ажиллагаа юм. 1989 онд "Их Долоо"-ийн шийдвэрээр FATF буюу санхүүгийн арга хэмжээ авах байгууллага нь Парис хотноо байгуулагдсанаар олон улсад мөнгө угаахтай тэмцэх тодорхой институцтэй болсон. Өдгөө тус байгууллага нь 35 гишүүн орон, 2 бүсийн байгууллагуудыг гишүүнээр элсүүлээд байна. Харин Монгол Улсын хувьд FATF гишүүн биш боловч FATF-ын төрлийн байгууллага болох APG (Ази, Номхон далайн бүсийн бүлэг)-ийн гишүүнээр 2004 оны зургаадугаар сард элссэн. Ер нь бол FATF-ын зөвлөмж, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бүсийн бүлгүүд байдаг ба газар нутгаасаа хамаарч улс орнууд бүсийн бүлэгтээ тайлангаа хүргүүлж, жилийн хурлаар хамгаалдаг байна.

FATF болон APG нь дэлхийн улс орнуудыг мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэхийг уриалан дэмждэг бөгөөд ингэхдээ, хэрэв гишүүнээр элсэж, стандарт, шаардлагуудыг нь мөрдлөг болгох юм бол Олон Улсад тухайн улсын эдийн засаг нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн эрсдэл багатай,

итгэлт түнш гэдгийг бусад орнуудад харуулах боломж нээгддэг. Харин шаардлагуудыг биелүүлэхгүй бол тухайн улсад тодорхой хугацаанд биелүүлэх боломжийг олгодог ба хэрэв хугацаа дуусахад биелүүлээгүй бол мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх эрсдэлтэй орон гэж хар, саарал жагсаалтад оруулна.

Монгол Улсад үүсээд байгаа нөхцөл байдал

Монгол Улсын хувьд 2006 оны долоодугаар сард Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталснаар Санхүүгийн мэдээллийн алба байгуулагдаж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааныхаа үндэс, суурийг тавьсан байдаг. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг үндсэндээ тухайн үеийн FATF-ын зөвлөмжид нийцүүлэн боловсруулсан. APG буюу ижил төстэй бүс нутгийн бүлгүүд нь гишүүн орнуудынхаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, FATF-ын зөвлөмжийн хэрэгжилтийг тодорхой хугацааны давтамжтайгаар тогтмол үнэлж, хянадаг.

Манай улс APG-ийн гишүүн орны хувьд FATF-ын 40 зөвлөмжийг мөрдлөг болгон, нийцүүлэх үүрэгтэй ба 2016 оны 11-р сарын байдлаарх харилцан үнэлгээний тайланг 2017 оны долоодугаар сард Шри-Ланк улсын Коломбо хотод хуралдсан жилийн чуулганы үеэр хамгаалсан. Харамсалтай нь зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалтгүй байсан тул Монгол Улсыг "эрчимтэй хяналтад" оруулж, 2018 оны 10 дугаар сараас өмнө холбогдох хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулж хэрэгжилтийг нь хангах үүрэг хүлээгэсэн. Хэрэв энэ үүргээ бүрэн гүйцэт биелүүлэхгүй бол Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдалд аюул учрахаар байгаа тул яаралтай арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Энд тэмдэглэхэд Монгол Улс анх удаа ийм нөхцөл байдалд ороод байгаа гэж ойлговол бас тийм биш юм. 2013 оны 10 сард болсон FATF-ын хурлаар манай улсын хууль эрх зүйн орчин, тэр дундаа Эрүүгийн

хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд хамаарах зохицуулалтыг FATF-ын зөвлөмжид нийцүүлээгүй гэсэн шалтгаанаар “өндөр эрсдэлтэй” болон “хамтран ажилладаггүй улс” гэсэн ангилал буюу “саарал жагсаалтад” оруулж байсан. Тус шийдвэр гарсаны дараа Монгол Улсын Их Хурал холбогдох хуулиудын нэмэлт өөрчлөлтийг яаралтай баталж, шаардлагыг биелүүлснээр 2014 оны 01-р сард жагсаалтаас гарч чадсан. Энэ 3 сарын хугацаанд Монгол Улсын гадаад төлбөр тооцоо саатаж, иргэд аж ахуйн нэгжүүдийг бухимдуулж байсан ч, тухайн үед манай гадаад харилцаа, эдийн засгийн хэмжээ өнөөдрийнхтэй харьцуулахад харьцангуй бага байсан учир нийт иргэдийн амьдрал, улсын эдийн засагт мэдрэгдэхүйц “доргио” үүсгэлгүй өнгөрсөн. Харин өнөөгийн нөхцөл байдал тухайн үеэс өөр бөгөөд, хэрэгжилт бүхий 40 зөвлөмж нь өргөн хүрээг хамарсан байгаа.

Нөгөөтэйгүүр өмнө нь харилцан үнэлгээг зөвхөн хууль, эрх зүйн тогтолцоог харж дүгнэдэг байсан бол одоо хоёр чиглэлээр үнэлдэг болсон. Ингэхдээ эхлээд тогтолцоо буюу хууль, журмууд зохих хэмжээнд боловсруулагдан батлагдсан эсэхийг үнэлнэ. Хоёрдугаарт, тухайн тогтолцоо хэр зэрэг үр дүнтэй ажиллаж байгаа буюу хэрэгжилтийг нь шалгадаг болсон. Манай улс үндсэндээ хоёр дахь үзүүлэлтээрээ хүнд байдалд ороод байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улс 2018 оны УИХ-ын хаврын чуулганаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг батлуулж, эрх зүйн орчноо сайжруулахаас гадна бидэнд олгосон хугацаа тулж ирээд байгаа учир тус хуулийн хэрэгжилтэнд ихээхэ чармайлт гаргах шаардлагатай. Зөвлөмжүүдэд хуулийн хэрэгжилт, үр дүн бүхий заалтууд багтсан учраас хууль батлагдсаны дараа хэрэгжилт буюу комплаенс тал дээр анхаарч ажиллах зүйлс их байгаа. Мөн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх нь дан ганц Санхүүгийн мэдээллийн албаны үүрэгт ажил бус Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, олон нийт гээд олон талуудын хамтын ажиллагааг хамардаг тул хэрэгжилт гэдэг нь нэг байгууллага эсвэл албан тушаалтнаас хамаарах зүйл биш юм.

Хийгдэж байгаа болон хийгдэхээр төлөвлөж байгаа ажлууд

Харилцан үнэлгээний дүнг сайжруулах үүднээс Засгийн газар, Монголбанк, Санхүү мэдээллийн алба хамтарч ажилласны үр дүнд Монгол Улсын

Ерөнхий сайдын 2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 70 дугаар захирамжаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл байгуулагдсан. Тус зөвлөл нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн бодлогын шийдвэр гаргадаг бол хэрэгжүүлэх үйл ажиллагааны төвшинд Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөл ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлөөс “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г Засгийн газарт хүргүүлсэн билээ. Уг төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12-р сарын тогтоолоор баталсан. Төлөвлөгөө нь дараах таван бүлэгтэй ба нийт 42 төрлийн ажлыг 22 яам агентлаг, Хамтын ажиллагааны зөвлөл хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчны зохицуулалтыг сайжруулах
2. Ерөнхий зохицуулалт, зохион байгуулалт
3. Хууль сахиулах байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ
4. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээ
5. Санхүү мэдээллийн алба болон бусад байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ

Монголбанкны хувьд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 баримтлах үндсэн чиглэлд холбогдох асуудлыг тусгайлан заасан байгаа. Мөн холбогдох байгууллагуудтай хамтран, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, улмаар Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлээд байгаа.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд, Монгол Улсад мөнгө угаах гэмт хэргээр ял авч байсан тохиолдол ганц ч байхгүй байгаа нь ихээхэн шүүмжлэлийг дагуулж байна. 2011 оноос хойш нийт 4345 иргэнийг мөнгө угаасан байж болзошгүй асуудлаар шалгаснаас 46 хэрэг мөрдөн шалгах шатанд шилжүүлсэн байдаг. Тэдгээр 46 хэргээс ердөө 2 хэргийг анхан шатны шүүхээс буруутайг нь тогтоож, шийтгэл ноогдуулах шийдвэр гаргасан ч хариуцагч талууд давж заалдсаар Дээд шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон. Үнээс манай улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо сонгодог утгаараа ажиллахгүй, хэрэгжилт хангалтгүй, хийх ажил их байгааг ажиглаж болох юм.

Улаанбаатар хотын инфляци 2 дугаар сарын байдлаар

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляци **2018 оны 2 дугаар сард** улсын хэмжээнд **6.9%-д**, Улаанбаатар хотын хэмжээнд **8.1%-д** хүрлээ.




Инфляци, түүний бүрэлдэхүүн



Улаанбаатар хот
инфляци
/жилийн/

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР



МОНГОЛБАНКНААС УЛИРАЛ БҮР ЭРХЛЭН ГАРГАДАГ
"МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" СЭТГҮҮЛИЙН ДӨРӨВ ДЭХ
ДУГААРААС ОНЦЛОВ.

Б.ЭНХБАЯР (Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд)

Монголбанкнаас "Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд" сэдвийн хүрээнд Орхон аймагт энэ оны нэгдүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан "Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган"-д Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаярын тавьсан илтгэлийн тоймыг Та бүхний анхааралд толилуулж байна.

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага болох ФАТФ (цаашид "ФАТФ" гэх) нь анх 1989 онд "Их долоо" гэгдэх улс орнуудаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх, үүнд бусад улс орныг хамруулах, хүчийг нэгтгэх зорилгоор үүсгэн байгуулагдсан ажээ. Тэгвэл Ази, Номхон далайн бүсийн байгууллага нь ФАТФ-ын бүс нутгийг хариуцсан салбар байгууллага бөгөөд Монгол Улс нь Ази, Номхон далайн бүсийн байгууллага (APG – Asia/Pacific Group on Money Laundering)-ын гишүүнээр 2004 оны зургаадугаар сард элссэн бөгөөд ФАТФ-ын 40 зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг билээ.

ФАТФ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх

олон улсын стандартыг багтаасан зөвлөмж болох бодлогын баримт бичгийг боловсруулан гаргадаг бөгөөд анхны зөвлөмжийг 1990 онд гаргаж, 1996, 2001, 2003, 2012 онд зөвлөмжийг шинэчлэн гаргаж байжээ. ФАТФ нь гишүүн улс орнуудын энэ талаарх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэхэд тодорхой хугацааны давтамжтай хяналт, шалгалт хийж, тухайн орны түвшинг үнэлэх Харилцан үнэлгээг хийдэг. Харилцан үнэлгээний дүнд хангалтгүй түвшинд хамаарах орныг нийтэд зарлах, эдгээр улс оронд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бусад гишүүн орнуудад анхааруулдаг байна.

Монгол Улсын тухайд дээр хэлсэнчлэн Ази, Номхон далайн бүсийн байгууллагын гишүүнээр 2004 онд элсэн, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид 2008

оны тавдугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсныг соёрхон баталж, "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" хууль 2006 оны долоодугаар сарын 8-ны өдөр батлагдсанаар Санхүүгийн мэдээллийн албыг байгуулж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлсэн билээ.

Мөн "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" хуулийн шинэчилсэн найруулга¹ 2013 оны тавдугаар сарын 31-ний өдөр батлагдлаа.

ФАТФ-ын Ази, Номхон далайн бүсийн байгууллага нь 2016 оны арваннэгдүгээр сарын 4-ний өдрийн байдлаарх мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоонд хоёр дахь удаагийн Харилцан

¹ <http://www.legalinfo.mn/law/details/9242?lawid=9242>

үнэлгээг хийж, 2017 оны долоодугаар сарын 19-23-ны өдрүүдэд Шри-Ланка улсын Коломбо хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн XX хурлаар Харилцан үнэлгээний тайланг баталгаажуулж, 2017 оны есдүгээр сарын 5-ны өдөр тус байгууллагын цахим хуудсанд албан ёсоор байршуулсан байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улс дахь тогтолцоог үнэлэх хоёр дахь удаагийн Харилцан үнэлгээ нь ФАТФ-аас 2012 онд шинэчлэн баталсан 40 зөвлөмжийн дагуу хийгдсэнээрээ ихээхэн онцлог байлаа. Өөрөөр хэлбэл, ФАТФ-ын зөвлөмжийн “техникийн хэрэгжилт буюу хууль, эрх зүй болон бодит байдал дээрх үйл ажиллагааны тогтолцоо” төдийгүй тогтолцооны “үр дүнтэй байдал”-ыг давхар үнэлснээрээ онцлог байсан юм.

Харилцан үнэлгээний тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн XX ээлжит хурлаар хэлэлцэхдээ Монгол Улсад 2018 оны аравдугаар сар хүртэлх 15 сарын хугацаанд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмж өгч, тухай бүрт тайлагнахыг үүрэг болгон “эрчимжүүлсэн хяналт”-д хамруулахаар тогтсон болно.

Манай орны хувьд Харилцан үнэлгээний техник хэрэгжилтийн үр дүнтэй байдлын үнэлгээг хангах үүднээс Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны дөрөвдүгээр сарын 20-ны өдрийн 70 дугаар захирамжийн дагуу Ерөнхий сайдын дэргэдэх “Үндэсний зөвлөл”-ийг Хууль зүй, дотоод хэргийн дэд

сайдаар ахлуулан, Сангийн дэд сайд, Гадаад харилцааны дэд сайд, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Улсын ерөнхий прокурорын орлогч, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга, Авлигатай тэмцэх газрын дэд дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга, Тагнуулын ерөнхий газрын тэргүүн дэд дарга, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга, Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Татварын ерөнхий газрын дэд дарга, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.

Үндэсний зөвлөл нь үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй бөгөөд энэхүү чиг үүргийн хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах ажлыг хийгээд байна.

Түүнчлэн 15 сарын эрчимжүүлсэн хяналтын хугацаанд нэн тэргүүнд хийгдэх ажлын төлөвлөгөөний хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, 2018 оны

нэгдүгээр сарын 3-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтоод байна.

Энэхүү хуулийн төсөлд Харилцан үнэлгээний тайлангийн зөвлөмжид заасан Санхүүгийн мэдээллийн албаны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлэх, санхүүгийн үйлчилгээний хөгжил, техник, технологийн өөрчлөлтөд нийцүүлэн “мэдээлэх үүрэгтэй этгээд”-ийн хүрээг өргөжүүлэх, тэдгээртэй холбоотой зохицуулалтыг нийцүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцлийг бүрдүүлэх, эдийн засгийн харилцаанд орж байгаа аливаа хөрөнгийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв, бодитоор бүртгэх тогтолцоог бүртгэлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх, хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, терроризмыг санхүүжүүлэхээс гадна үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтыг тусгах, Засгийн газрын түвшний Үндэсний зөвлөл зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох зохицуулалтыг тусгаад байна. Тухайлбал, ФАТФ-ын 40 стандарт зөвлөмжид заасны дагуу “нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч” нь харилцагчийн нэрийн



“үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах бол; харилцагчийн хөрөнгийг удирдах бол; банк, хадгаламж, үнэт цаасны дансыг удирдах бол; компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах бол; хуулийн этгээдийг, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа нэгдэл, холбоог үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах бол; эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах бол” мэдээлэх үүрэгтэй байхаар, түүнчлэн “терроризм, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх хуулийн бүхий л зохицуулалтад “үй олноор

хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэх”-тэй тэмцэхэд нэг адил хамаарахаар, эцсийн өмчлөгчийг шалган тогтоох дарааллыг тодорхой байхаар, улс төрд нөлөө бүхий этгээдэд “гадаад улсын төрийн байгууллагын албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтан”-г хамруулахаар тусгаж, үүнтэй уялдуулан хуулийн холбогдох зохицуулалтыг нэмж, өөрчлөх ажлыг хийлээ.

Ингэснээр Монгол Улсын ажиглалтын үе буюу 2018 оны аравдугаар сараас өмнө ФАТФ-ын 40 зөвлөмжид хууль, эрх зүйн орчинг нийцүүлж, хэрэгжүүлснээр эрчимтэй хяналтаас гарах боломж бүрдэнэ.

Манай орон ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орох эрсдлээс урьдчилан сэргийлж чадсанаар санхүүгийн салбарын гадаад харилцаанд шууд нөлөөлж, түншийн харилцаа зогсонги байдалд орох, хөрөнгө оруулалт татах боломж буурах буюу хязгаарлагдах, банкны гадаад гүйлгээ зогсох гэх мэт манай орны эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд шууд нөлөөлөх сөрөг үр дагавраас сэргийлж чадах ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, улс орны зээлжих зэрэглэл буурч, Засгийн газар болон аж ахуйн нэгжийн хөрөнгө босгох зардал өссөнөөр инфляцид сөргөөр нөлөөлж болзошгүй төдийгүй үүсэх сөрөг үр дагавар нь өмнө саарал жагсаалтад орж байснаас хавьгүй их байх магадлалтай юм.



Ононгийн ОРХОН

ТОВЧ НАМТАР

Овог: Онон

Нэр: Орхон

Албан тушаал: ХХБ-ны гүйцэтгэх захирал

О.Орхон нь 2007 оноос 2016 оны 1-р сар хүртэл Худалдаа, Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, 2016 оны 1-р сараас Гүйцэтгэх захирлын албан тушаалд ажиллаж байна. Тэрээр Монголын Мянганы Сорилтын Санд Санхүүгийн зөвлөх, Улаанбаатар хотын банкинд Гүйцэтгэх захирал, ХХБ-ны Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч албан тушаалд тус тус ажиллаж байсан. Мөн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөх, Монголын Эдийн засгийн хөгжлийн сайдын зөвлөх болон Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалыг хашиж байсан бөгөөд банк, санхүү, бизнесийн салбарт 20 гаруй жил ажиллаж буй туршлагатай банкир юм.

Ноён О.Орхон нь Ти Ди Би Капитал ХХК болон Ти Ди Би Лизинг ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар, 2014 оноос Монголын банкны холбооны Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан ба одоо Ти Ди Би Лизинг ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

Тэрээр 1993 онд ОХУ-ын Ярославль хотын 9-р дунд сургууль, 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг төгсөж, банкны эдийн засагч, санхүүч мэргэжил эзэмшсэн. 2003 онд Их Британи улсын Уэльсийн их сургуульд Банк санхүүгийн бизнесийн удирдлагын Магистр цол хамгаалсан.

О.ОРХОН: МОНГОЛЫН БАНКНЫ САЛБАР ОЛОН УЛСЫН СТАНДАРТААС ХОЛ ЗӨРӨӨГҮЙ

ХХБ-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
О.ОРХОНТОЙ ЯРИЛЦЛАА.

► **Олон улсад банк санхүүгийн салбарт юу трэнд болж байгаа талаар юуны өмнө мэдээлэл хуваалцана уу?**

-Сүүлийн үед "digital banking" гэдэг зүйл л нэлээд эрчтэй хөгжиж байна. Цахим ертөнц хөгжихийн хэрээр маш олон финтек//компаниуд гарч ирж, банкны үйл ажиллагааг хялбар, түргэн шуурхай болгох, зардал багатай, харилцагчдад илүү нээлттэй түргэн шуурхай хүргэх олон гарцууд бий болж байна. Энэ нь нэг талаараа банкны бизнестэй өрсөлдөөд ч байгаа юм шиг. Нөгөө талаасаа бас хамтарч ажиллаж болохоор ч юм

шиг харагдаж байгаа. Ерөнхийдөө дэлхий даяар банкууд үүнийг хүлээн зөвшөөрч эхэлж байна. Тийм учраас харилцагчдын хөрөнгө, мөнгийг хадгалах, зээл олгох, санхүүгийн зуучлалын үүргээ гүйцэтгээд, төлбөр тооцоо гэх зэрэг үүргийг финтекүүд гүйцэтгэж болох юм гэж үзэж байгаа. Сая Европын Холбоо банкны үйл ажиллагааг журамлах хүрээндээ шинэ дүрэм, журам гаргасан. Тэр нь финтекүүдтэй яаж хамтарч ажиллах вэ, хэн нь ямар хариуцлагатай байх вэ гэдгийг зохицуулсан. Тэгэхээр банкуудын зарим нь финтек компаниудтай хамтран ажиллаж байна. Зарим нь худалдан

авч байна. Зарим нь өөрсдөө дотооддоо шинэ технологиудыг нэвтрүүлэх ажлыг хийж байна. Зарим нь өмнө нь тодорхой хэмжээнд цахимжуулчихсан, тодорхой хэмжээнд дижитал болгосон байсан үйл ажиллагаагаа дахин сэргээж эхэлсэн гэх зэргээр "манай банк дижитал болж байгаа" гэдэг мессежийг бүхий л банк өгөхийг эрмэлзэж ажиллаж байна. Банкууд зөвхөн өөрсдийнхөө банкны том брэнд, нэр хүндээрээ харилцагчид руугаа маркетинг хийдэг байсан бол одоо дижитал банк, цахим сувгуудаа ашигласан шинэ брэндүүдийг бий болгох

трэнд гарч ирж байна. Жишээ нь манай банкны хувьд сая дижитал банкны шинэ бүтээгдэхүүн болох TDB Pay гэх шинэ брэндээ гаргаж ирлээ. Энэ нь зөвхөн төлбөр тооцоо гүйцэтгэдэг аппликэйшн биш. Дотроо зээл, төлбөр тооцоо, хадгаламж, дансны удирдлага, бэлэн мөнгө зэрэг банкны бүх төрлийн үйлчилгээг багтаасан цогц бүтээгдэхүүн болж байгаа.

► **Тэгэхээр манай банкны салбарт энэ үйл ажиллагаа бүрэн нэвтрэх боломжтой гэж ойлгож болох нь. Дэлхийтэй “хөл зэрэгцэх” технологийн шийдлийг нэвтрүүлэхэд цаг хугацаа, нилээдгүй хөрөнгө оруулалт шаардлагатай байх?**

-Програм хангамжийн тухайд зөвхөн Америк, эсвэл Энэтхэгийн том компаниуд хийдэг цаг үе өнгөрсөн. Ялангуяа манай Монголын залуучууд яг мэдээллийн технологийн салбарт дэлхийд өрсөлдөхүйц хэмжээнд болж байна. Дээрээс нь заавал банкны бүх системийг мэддэг, чаддаг, бичдэг байх албагүй. Тухайн системтэй нээлттэйгээр холбогдож болдог эрин, цаг үе ирж байна. Тийм учраас одоо маш өндөр өртгөөр шинэ технологи нэвтрүүлэхээ больсон. Заавал гадны компанийг хөлсөлж авах шаардлагагүй болсон байгаа үед бид аль болох нээлттэй байж, хэн илүү хурдтай, сайн ажиллаж байна, тэр компаниудтай хамтран ажиллах стратегитай байгаа. Манай банкны дижитал стратеги ч бас яг үүн дээр тулгуурлаж, Монголын болон гадаадын бүхий л технологи, инноваци, ур чадвар сайтай компаниудтай нээлттэй хамтран ажиллахыг зорьж байна. Програм хангамжийн хувьд ч бас бид өөрийн үндсэн програмтай нээлттэйгээр холбогдох боломжийг бүрдүүлээд ажиллаж байгаа. Зохицуулалтын хувьд одоогоор Монгол Улсад хэрэгжиж байгаа Банкны тухай

хууль, дүрэм журмаас гажаад байх зүйл байхгүй.

► **Мэдээж, санхүүгийн хэрэглэгчийн ая тухыг бүрэн хангахад чиглэсэн цахимжсан үйлчилгээнүүдийг банкууд сонгох болжээ гэж ойлголоо.**

-Тийм ээ. Өнөөдрийн бидний цахим, дижитал үйлчилгээг нэвтрүүлж байгаагийн цаад зорилго нь эцсийн дүндээ харилцагч төвтэй л үйлчилгээ юм. Харилцагчийн сэтгэл ханамжийг дээд цэгт хүргэх тэр стратеги руу хүссэн хүсээгүй явахыг хичээж байна. Тэгэхээр бид технологид хөрөнгө оруулалт хийж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж байгаа нь харилцагчид маш том давуу талыг авчирч байгаа. Заавал банкинд очиж үйлчлүүлэхгүйгээр зайнаас бүх төрлийн үйлчилгээг авах боломжтой. Сүүлийн үед зээлийн үйлчилгээг хүртэл банкинд очихгүйгээр шийдүүлэх боломжтой болж байгаа. Зөвхөн банкууд үүнийг хийхээс гадна банк бус санхүүгийн байгууллагууд ч нэвтрүүлж эхэлж байна. Саяхан Lend.mn гэж компани IPO хийж, яг энэ чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулахаа зарлаад байна.

► **Хэдийгээр шинийг эрэлхийлж, хийж бүтээж байгаа ч энэ салбарт таны сэтгэлийг юу их чилээж байгаа талаар ярилцахыг хүсч байна.**

-Банкны салбарын хууль, эрх зүйн орчин саяхан шинэчлэгдлээ. Энэ хүрээнд Монголбанкинд олон дүрэм, журмыг өөрчилж шинэчлэхээр ОУВС-ийн зөвлөгөөг аваад ажиллаж байна. Дээрээс нь банкууд олон улсын бүртгэлийн тогтолцоо руу шилжиж эхэллээ. Өөрөөр хэлбэл, манай банкны системд олон улсын стандарт нэвтрэх процесс маш эрчимтэй явагдаж байна. Зохицуулалтын хувьд, бизнесийн стандарт, харилцагчийн

үйлчилгээ, аюулгүй байдал, олон улсын цахим бүтээгдэхүүн үйлчилгээ гээд бүх талаараа бид олон улсын стандартыг хангахын төлөө ажиллаж байна. Энэ бол маш зөв зүйтэй зүйл. Харамсалтай нь бидний бизнесийн хүрээ тэр хэрээр тэлж чадахгүй байна. Банкууд бүх эдийн засгийн ачааг нуруун дээрээ үүрч явна гэж шүүмжлүүлдэг ч нөгөө талдаа энэ бол бидэнд хэтэрхий том ачаа, эрсдэл. Тэгэхээр хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх гэдэг асуудлыг олон жил ярьсан. Үнэхээр энэ асуудал маш чухал. Энэ гурван тулгуурыг хөгжүүлж байж, санхүүгийн тогтвортой байдлын тухай ярих хэрэгтэй. Зөвхөн банкны салбарт ачааны ихэнхийг үүрүүлчихээд санхүүгийн тогтвортой байдлын тухай ярих нь өрөөсгөл юм. Бизнесийн хувьд яагаад боломж бага байна вэ гэхээр нэгдүгээрт, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр банкууд маш их ажил хийж, анхаарч байсан. Харамсалтай нь бидний үйл ажиллагаа энэ тал дээр хязгаарлагдмал хэвээрээ байна. Хоёрдугаарт, Монгол Улсын уул уурхайн цикл дээр тогтсон эдийн засаг маань сайн тэлж өгөхгүй байна. Өөрөөр хэлбэл, бизнесийн тогоо маань томрохгүй байгаа учраас өнөөдөр яг аль секторыг бодлогоор дэмжиж, ямар бизнест зээл олгох юм бэ гэдэг асуудал тулгарч байна. Нэг хэсэг уул уурхай дэлгэрч байх үед энэ салбарт маш их санхүүжилт өгч, зээл олгосон. Харамсалтай нь уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлт, бууралтыг дагаад манай улсын эдийн засаг тэр чигээрээ савалдаг. Энэ нь банкуудын активын чанарт нөлөөлж, тэрнээсээ болж банкууд уул уурхайн салбарт олгох зээлийн бодлогоо нэлээд чангаруулсан. Өөрөөр хэлбэл, цаашдаа тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа,



томоохон уул уурхайн компанид л тодорхой хэмжээний зээл олгох. Түүнээс биш салбарын компани болгонд зээл олгох нь өөрөө эрсдэл дагуулдаг юм байна гэдгийг бид өмнөх алдаан дээрээсээ суралцсан. Дээрээс нь барилгын салбарын зээл. Улаанбаатарт боссон томоохон оффис, орон сууцны барилгууд, барилгын салбарын ханган нийлүүлэлт гээд энэ бүхэнд шаардлагатай санхүүжилтийг бараг 100 хувь дотоодын банкууд маань гүйцэтгэсэн. Гэвч эдийн засаг хүндрэхийн хэрээр энэ салбарт ч бас борлуулалт муудаад, зээлийн чанарт нөлөөлөөд эхэлсэн. Тийм учраас энэ секторт ч бас хэмжээ, хязгааргүй зээл олгож болохгүй юм байна гэдэг нь харагдаад эхэлсэн.

► Энэ бүхний суурь шалтгаан нь манай эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгож байгаа мөчлөг болоод тогтворгүй бодлоготой холбоотой гэж та үзэх үү?

- Мөн. Тогтворгүй бодлого. Манай улсын эдийн засгийн цикл.

Жижиг эдийн засаг буюу тогоогоо томруулж чадахгүй байгаа учраас эрэлт, нийлүүлэлт маш хурдан ханаж байна л даа. Цаашдаа бизнесийн ямар салбарт голлох санхүүжилтийг олгох вэ гэдэг л бидний толгойны өвчин болж байна. Жижиг, дунд үйлдвэрлэл, манай улсын эдийн засгийн ирээдүй гээд бодвол маш олон төсөл, хөтөлбөрийн хүрээнд олон улсын байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнд нь энэ сектор маань бас л ханаж эхэлж байна. Гэтэл иргэдийн зээлийг бас хэмжээ хязгааргүй нэмж болохгүй. Монгол Улсынхаа ажил эрхэлж байгаа иргэн бүрийг ямар нэгэн байдлаар өр, зээлтэй болгоод байж болохгүй гэсэн үг. Энэ нь цаашдаа ямар нэгэн хөөсрөлт бий болгох эрсдэлтэй учраас бид болгоомжтой хандах ёстой. Тэгэхээр өнөөдрийн банкуудын бодит байдал нь маш өндөр хэмжээний хөрвөх чадвартай. Асар их хэмжээний хөрөнгийг төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаасан дээр

байршуулчихсан. Эдийн засагтаа оруулж чадахгүй, ийм байдалтай байна. Шинэ бизнес, шинэ төсөл төдийлөн гарч ирэхгүй байна. Тийм учраас одоо үйл ажиллагаа явуулж байгаа сайн компаниудаа л хоорондоо хүүгээр өрсөлдөх маягаар тогтоон барьж байна. Энэ нь зөвхөн Монголд үүссэн нөхцөл байдал биш л дээ. Манай бүс нутагт ийм асуудал тулгараад байгаа. Тэгэхээр банкуудын ашигт ажиллагаа, эдийн засагтаа оруулж байгаа хувь нэмрийн тухайд чухам хаашаа явж байна вэ гэдэг дээр л том асуултын тэмдэг байна даа.

► Энэ мэт хүндрэл нь мөнгөний бодлогын хүүний шийдвэр гаргахад хүртэл ярвигтай байдаг байх.

Яагаад гэвэл, манай улсын хүү тогтож байгаа тогтолцоо нь яг инфляци, эсвэл бодлогын хүүтэйгээ шууд хамааралтайгаар уяан, хатан тогтдоггүй. Зүгээр олон жилийн туршлага, олон жилийн дунджид үндэслэсэн, ирээдүйн эрсдэлээ нэлээд бодож, тогтоосон хүү байгаа. Тийм ч учраас хэт өндөр байна гэх шүүмжлэл бий. Инфляцийн хувьд нэлээд олон жил хоёр оронтой тоонд байсан. Сүүлийн хэдэн жилд л нэг оронтой тоонд тогтворжиж байна. Цаашдаа олон жил нэг оронтой тоонд, тогтвортой байвал банкуудад хадгаламжийн хүүгээ бууруулах нөхцөл бий болно.

► Тогтвортой эдийн засгийн төлөө бидэнд суурь тунхаг алга байна шүү дээ.

- Манай улсад өнөөдөр юу дутагдаж байна вэ гэвэл бодлого дутагдаж байна. Бодлогын залгамж халаа дутагдаж байна. Бүх төвшний шийдвэр гаргагчид нэг зүгт харах алсын хараа, стратеги, төлөвлөлт үнэхээр дутагдаж байгаа. Өнөөдөр Монгол Улсын нийгэм, эдийн засаг яаж хөгжих вэ, ирээдүйд 20-30 жилийн дараа хаана байх вэ,

эдийн засаг, нийгмийн хөгжлөөр бүс нутагтаа ямар байр суурь эзлэх вэ гэдэг асуудлаар хариулт өгч, шийдлийг олж байгаа хүмүүс харамсалтай нь алга. Тэгэхээр бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зөвшилцөл зайлшгүй шаардлагатай. Бид цаашдаа олон жил оршин тогтнож, хөгжсөөр байх болно. Олон төр засаг, эрх баригчид солигдоход зөвшилцөл үргэлжилж байх ёстой. Үүнийг бие даасан төв банк нь ч тэр, Засгийн газар, аж ахуйн нэгжүүд, санхүүгийн секторт оролцож байгаа банкууд ч тэр хүлээн зөвшөөрч, алсын хараатай, залгамж чанартайгаар авч явах ёстой. Тэгж байж, тогтвортой хөгжилд хүрнэ. Өнөөдөр тогтвортой хөгжлийн асуудлыг яагаад хөндөж байна вэ гэхээр эдийн засаг сайн байх үед улс төрчид өөр бодлого явуулдаг. Нийгмийн халамжийг өсгөдөг, төсвийн зардлыг тэлдэг, валютын нөөцийг үрэн таран хийхэд л анхаарч ажилладаг. Гэтэл эдийн засаг муудаад эхлэхээр төсвөө чангалдаг, халамжаа танадаг. Энэ бүгд нь эцсийн дүндээ ард түмний амьдралыг савлуулж, бизнес хийх орчныг савлуулж байгаа. Компаниуд бизнесээ урт хугацаагаар төлөвлөх боломжийг шууд үгүй хийж, маш их эрсдэл дагуулж байгаа учраас энэ бодлого тогтвортой байж, үндсэн зарчмаа барьж явах ёстой. Эдийн засгийн уналт, өсөлтийн аль ч үед тогтвортой бодлогоо барьж чадвал эдийн засгийн тогтвортой өсөлт бий болно гэж үзэж байгаа.

► 2017 он банкны салбарын хувьд сорилтын жил боллоо. Активын чанарын үнэлгээ хийгдлээ, Банкны салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэлтүүд хийгдэж эхэллээ. Та бүхэн энэ сорилтод хэр бэлтгэлтэй байв?

-Бидний бизнесийн орчин орвонгоороо эргэсэн ч юм уу, маш том нөлөө үзүүлэх өөрчлөлт биш л дээ. Үндсэндээ банкны олгож

байгаа зээлүүдийг илүү хяналттай болгох, олон улсын стандартад нийцсэн хяналт, шалгалтыг бий болгох, ирээдүй рүү харсан, эрсдэлд үндэслэсэн тогтолцоог бий болгож байна. Энэ нь банкны системийн цаашдын хөгжилд хэрэгтэй зүйл. Сайн тал нь бид активын чанарын үнэлгээг сайн дааж гарлаа. Европын холбооны гаргасан дүрэм, журам, стандартаар шалгууллаа. Өөрөөр хэлбэл, бүгдээрээ 10 жилийн төгсөх шалгалтанд л бэлдэж, шалгуулдаг байсан бол энэ удаад олон улсын их сургуулийн шалгалтын зарчмаар бид шалгагдлаа. Бид үүнийг сайн давж гарсан. Монголын банкны салбар олон улсын стандартаас хол зөрөөгүй учраас шинэ хууль эрх зүйн орчин, стандарт банкуудын үйл ажиллагаанд тийм ч их хүндрэл учруулахгүй байх. Харин бизнес талаасаа бол нэлээд хумигдах байх. Яагаад гэвэл энэ бүх тавьж байгаа шалгуур нь банкны үйл ажиллагаа, удирдлага, менежмент, стратегид нөлөөлж байгаа зүйл биш. Гол зорилго нь банкны аж ахуйн нэгж, зээлийн үйл ажиллагаанд тавьж өгч байгаа хязгаарлалтууд юм. Тэгэхээр Монголын компаниуд санхүүгээ яаж хөтөлдөг билээ. Олон улсын нягтлан бодох, санхүүгийн стандартад улс даяараа хараахан шилжиж амжаагүй байна. Компаниудын санхүүгийн байдал хүнд, татварын болон бусад янз бүрийн шинэчлэлүүд явж байна. Энэ бүхэн аж ахуйн нэгжүүдэд яаж нөлөөлөх нь тодорхойгүй байгаа учраас банкууд шинээр батлагдсан Банкны тухай хуулийн хүрээнд зээлдэгчдэд тавих шаардлагаа чангатгахаас өөр аргагүй болж байгаа. Учир нь шалгалт өөрөө банкуудыг шалгаж байгаа биш. Банкууд харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хэрхэн зөв, оновчтой байршуулж байна вэ гэдгийг л шалгаж байгаа. Тийм учраас бид шалгуураа чангатгах шаардлага тулгарч байгаа.

“Монголын банкны салбар олон улсын стандартаас хол зөрөөгүй учраас шинэ хууль эрх зүйн орчин, стандарт банкуудын үйл ажиллагаанд тийм ч их хүндрэл учруулахгүй байх.”

► Тэгэхээр та бүхэн харилцагчдадаа урьдчилж мэдээллийг маш сайн өгч, хамтран ажиллах шаардлагатай байх нь?

-Өмнө нь бид олон жилийн хамтын ажиллагаа, тухайн компанийн туршлага, менежмент, удирдлагын ур чадвар, зах зээлд эзэлж байгаа байр суурь, хурд гэх зэрэг олон тоонд бус чанарын үзүүлэлтээр дүгнэдэг байлаа. Дээрээс нь барьцаа хөрөнгийг ч хангалттай үнэлж авдаг. Энэ нь шалгалтыг амжилттай даван туулахад нэмэр болсон гэж үзэж байгаа. Цаашдаа бид илүү олон улсын стандартын дагуу бүртгэл, санхүүгийн тайлан, өөрийн хөрөнгийнхөө хэдэн хувьтай тэнцэх өр, төлбөр, бизнесийн мөнгөн урсгал, ирээдүйн орлого гэх зэрэг олон зүйлийг харж, үнэлнэ. Дээрээс нь барьцаа хөрөнгийн үнэлгээ, эдийн засаг унахад түргэн борлогдох чадвар ямар байна вэ гэх зэрэг маш олон зүйлээр зээлдэгчдийг судлах шаардлага бий болж байгаа. Энэ бүхэнд манай аж ахуйн нэгжүүд бэлэн биш байна. Цаашдаа зөвхөн банкууд нь хөгжөөд, олон улсын стандарт нэвтрүүлэхийг шаардах бус нийтээрээ олон улсын стандарт нэвтрүүлэх шаардлага бий болж байна.

► Барьцаа хөрөнгийн үнэлгээний тухайд, банкууд барьцаа хөрөнгийг хэт доогуур үнэлж байна гэх шүүмжлэл өрнөдөг. Энэ тал дээр олон улсын шалгуурыг хэрхэн давж гарсан бэ?

-Шалгалтаар банкуудын барьцаа хөрөнгийг олон улсын стандартаар үнэлсэн. Өөрөөр хэлбэл, банкууд барьцаа хөрөнгөө зөв үнэлж байна уу гэдгийг авч үзсэн. Үүн дээр Монголын банкуудын үнэлсэн байдал нь Активын чанарын үнэлгээний шаардлагаас дээгүүр гарсан. Өөрөөр хэлбэл,

бид барьцаа хөрөнгийг хэт доогуур үнэллээ гэж шүүмжлэгддэг ч олон улсын стандартаар үнэлээд үзэхэд Монголын банкуудын үнэлснээс доогуур гарч байгаа. Гэхдээ тийм өндөр, 20-30 хувийн зөрүү гараагүй. Тэгэхээр бид хангалттай сайн үнэлж авч байна л гэсэн үг. Гэхдээ цаашдаа бид энэ үнэлгээг нэмэгдүүлэх нь эрсдэлтэй юм байна гэдгийг харсан.

► Монголчууд нийтээрээ том мөрөөдөлтэй байж, олон улсын зах зээл рүү тэмүүлэх ёстой. Танай банк харин зориглосон шүү дээ.

-Бидэнд өнгөрсөн хугацаанд ийм боломж байсан уу гэвэл байсан. Дэлхийн санхүүгийн зах зээл ид хөөсөрч байх ид үед олон улсын зах зээл дээр гарч, IPO хийх талаар маш их санал гардаг байсан. Тэр үед харамсалтай нь Монголын эдийн засаг хэр том байсан билээ. Үнэндээ Монголын хамгийн том банк IPO хийхэд 250-хан сая ам.долларын л тухай яригдахаар байсан. Үүний дараа 2008 оны эдийн засаг, санхүүгийн хямралаас хойш 2011, 2012 онд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ огцом өсч, Оюутолгойн хөрөнгө оруулалт эхэлж, Монголыг маш олон гадны хөрөнгө оруулагчид сонирхож байх үед бидэнд бас л боломж байсан. Цаашдаа ч бас ийм боломж бидэнд гарах байх гэж найдаж байгаа. Тэгэхээр өнөөдөр бид банкныхаа бүхий л үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдал, санхүүгийн бүртгэл гээд бүх талаараа олон улсын стандартыг хангаж байна. Энэ нь өөрөө Монголоос нэг ч гэсэн банк олон улсын зах зээл дээр гарах ёстой гэдэг мөрөөдөл, стратеги дээр үндэслэж байгаа. Бид хэзээ нэгэн цагт зах зээл тогтвортой болоод, Монгол руу дахиад гадаадын хөрөнгө оруулалт урсаад, эдийн засаг маань томроод, Монголын эдийн засаг,

банк санхүүгийн салбарт итгэх итгэл нэмэгдэх үед дахиад IPO хийнэ гэж бодож байгаа.

► Цаг хугацаа хэр орох бол?

-Яг IPO хийхэд бол нэг их хугацаа орохгүй. Гагцхүү бэлтгэл ажил чухал. Банк маань өөрөө олон улсын зах зээл дээр танигдсан байх, хөрөнгө оруулах сонирхол, итгэл бий болсон байх гээд олон зүйлээс хамаарна. Энэ бүгдэд цаг хугацаа орно. Гэхдээ бид аажим аажмаар бэлдээд л явж байгаа. Монгол Улсаас нэг ч гэсэн банк олон улсын зах зээл дээр нээлттэй, IPO хийх, олон улсын зах зээл дээр танигдсан байх, олон улсад өөрийн салбар нэгжээ байгуулах гэсэн стратегитай ажиллаж байна.

Ярилцлагаа үүгээр өндөрлөө баярлалаа.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 29/III ӨДРИЙН БАЙДЛААР)**



NOBEL
PRIZE
ECONOMICS



**2004 ОНЫ
НОБЕЛИЙН
ШАГНАЛ
– ФИНН
КИДЛАНД,
ЭДВАРД
ПРЕСКОТ
НАРЫН МАКРО
ЭДИЙН ЗАСГИЙН
ДИНАМИК
ТЭР ДУНДАА
БОДЛОГЫН ЦАГ
ХУГАЦААНЫ
ҮР НӨЛӨӨТ
БАЙДАЛ,
БИЗНЕСИЙН
МӨЧЛӨГИЙН
ТАЛААР ХИЙСЭН
СУДАЛГАА**

Хөрөнгийн татвар нэмэгдэх хандлага үүсэх үед айл өрх, иргэдийн хуримтлалын төвшин буурах байдал ажиглагддаг. Харин Төв банк мөнгөний зөөлөн бодлого явуулж, инфляцийг нэмэгдүүлэх мессеж өгөхөд компаниуд бүтээгдэхүүнийхээ эсвэл цалингийн хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг байна. Монгол Улсын хувьд жишээлбэл хадгаламжийн хүүнээс 10 хувийн татвар авч эхлэх мэдээлэл гарсанаас хойш засгийн газрын үнэт цаасны эрэлт нэмэгдсээр 2017 оны 04-р сарын 01 буюу хууль хэрэгжиж эхлэхэд дээд цэгтээ хүрсэн байдаг.

Нобелийн шагналыг эдийн засгийн салбарт 2004 онд хүртсэн Финн Кидланд болон Эдвард Прескотт нар нь макро эдийн засгийн суурь ойлголтууд болох эдийн засгийн бодлогуудын цаг хугацааны үр нөлөөт байдал болон бизнесийн мөчлөгийн хэлбэлзэлийг нөхцөлдүүлэгч гол хүчин зүйлсийн талаар судалж, дэвшил авчирж чадсан. Тэдний бүтээлүүд нь эдийн засгийн академик судалгаа ба амьдрал дээрх макро эдийн засгийн бодлогын хэрэгжилт, шинжилгээнд өөрчлөлт авчирж, цоо шинэ судалгааны парадигм буюу онолын загварыг бий болгосон юм.

Багш шавь хоёрын хамтын бүтээл

Хэдийгээр Финн Кидланд, Эд Прескотт хоёр ердөө 3 насны зөрөөтэй ч гэсэн Кидландын докторын ажлыг Прескотт удирдаж, хамгаалахад нь дэмжлэг үзүүлсэн байдаг. Прескотт нь докторын ажлаа Карнеги Меллон их сургуульд 1967 онд хамгаалсан ба 1971 онд Кидландын докторын сэдвийг сүүлийн жилд нь удирдах болсоноор урт хугацааны нөхөрлөл, хамтын ажиллагааны

эхлэл нь тавигдсан.

Финн Кидланд бол Норвегид төрж, өссөн эрдэмтэн. Тэрбээр докторын ажлаа “Төвлөрсөн бус макро эдийн засгийн төлөвлөлт” сэдвээр бичиж байсан. Кидландыг докторын зэргээ хүртсэний дараахан Карнеги Меллон их сургуульд багшлах санал авсан боловч өөрийн бакалаврын зэргээ хүртсэн Норвегийн эдийн засгийн сургуульд ажиллах шийдвэр гаргаж, ингэхдээ Эдвард Прескоттыг урьж хамтран ажиллах санал тавьсан байдаг.

Хоёр эрдэмтэний 1977 онд бичиж, хэвлүүлсэн судалгааны өгүүлэл нь макро эдийн засгийн онолын судалгаанд томоохон нөлөө үзүүлээд зогсохгүй стагфляци зэрэг бодлогын бодит асуудлыг шийдвэрлэх замыг бий болгожээ. Стагфляци гэдэг нь эдийн засгийн уналт буюу зогсонги байдалтай хамт инфляци өсөхийг хэлдэг. Иррациональ, оновчтой биш бодлогын шийдвэр нь стагфляцийг нөхцөлдүүлэхээс илүү бодлого тодорхойлогч нар мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлж чадахгүй байгаад учир оршиж байна гэж тэд дүгнэжээ. Энэхүү дүгнэлт нь ч 1990-ээд оноос олон улсын Төв банкуудад тусгалаа олж, хараат бус — бие даасан байдлаа сайжруулах гэх мэт өөрчлөлтүүдийн шалтгаан болсон.

Макро эдийн засгийн бодлогуудын цаг хугацааны үр нөлөөт байдал

Мөнгөний бодлогын шийдвэр, ялангуяа бодлогын хүүгийн шийдвэр нь эдийн засгийн ирээдүйн прогноз, тоон үзүүлэлтүүд дээр үндэслэж гардаг. Мөн шийдвэр гаргах болон, ирээдүйн талаарх мессежийг өгөхдөө Төв банкууд иргэд, бизнес эрхлэгчдийн хүлээлтийг чиглүүлэх давхар

зорилготой байдаг. Гэвч мөнгөний бодлогын шинээр гарсан шийдвэр өмнөхтэйгээ зөрчилдсөн үед цаг хугацааны үр нөлөөт байдал алдагддаг байна. Үүний нэг жишээ бол 1970-аад оны үед газрын тосны үнийн хямралын үед Төв банк, Засгийн газрууд инфляцийг нам дор төвшинд барина гэж зорьж байсан ч давхар ажилгүйдлийн төвшинг бууруулах амлалтыг өгч байсан. Харамсалтай нь газрын тосны нийлүүлэлт буурснаар хэрэглээний бүтээгдэхүүнүүдийн үнэ өсч, мөнгөний хатуу бодлог хэрэгжүүлэх шаардлага үүссэн ч мөн ажилгүйдлийн төвшинг бууруулах өөр нэг шийдвэр гарч байсан нь цаг хугацааны үр нөлөөт байдлыг алдагдуулж байсан аж.

Финн Кидланд, Эд Прескоттын судалгаанд Милтон Фридман, Эдмунд Фелпс, Роберт Лукас нарын онолууд тусгалаа олсон байдаг. Бид “Монголбанкны Мэдээлэл” товхимлын өмнөх дугаарт Фелпс болон Фридман нарын нээлт буюу Филлипсийн муруйг урт хугацаанд өөрчлөн, хүлээлтэд тулгуурласан Филлипсийн муруйг зурж, бодит инфляци ажилгүйдлийн төвшин хоёр инфляцийн хүлээлтээс хамаардагийг тайлбарласан билээ. Харин 1995 оны Нобелийн шагналыг хүртсэн Роберт Лукас эдийн засагт оролцогч талууд ирээдүйн нөхцөл байдал, прогноз дээр үндэслэж хамгийн рациональ, оновчтой шийдвэрийг гаргадаг ба цаг хугацааны явцад тохируулга хийдэг гэж рациональ хүлээлтийн онолд хувь нэмрээ оруулсан.

Цаг хугацааны үр нөлөөт байдалд бодлого тодорхойлогч нар өмнө гаргасан, цаашид гаргах шийдвэрүүдээ харилцан уялдаатай гаргаж байж эдийн засгийн бодит үр нөлөөг үзнэ гэж

тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл энд хэлсэндээ хүрэх маш том амлалт явж байгаа аж. Хэрэв Төв банк, Засгийн газар хэлсэндээ хүрч, бодлогын шийдвэрүүдийг харилцан уялдаатай гаргаж чадах юм бол иргэд, бизнес эрхлэгчид зэрэг эдийн засгийн оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлж, хүлээлтэд бодитойгоор нөлөөлж, чиглүүлэх бололцоо бүрдэх юм. Ингэснээр шийдвэр гаргалтууд илүү оновчтой болж, эдийн засгийн тогтвортой байдлыг баталгаажуулна.

Бизнесийн мөчлөгийн хэлбэлзлийг нөхцөлдүүлэгч гол хүчин зүйлс

Бизнесийн мөчлөгийн онолд Кейнсийн судалгаа томоохон байр суурь эзэлдэг ба 1960-аад оныг дуустал давамгайлж нөлөөтэй байсан. Гэвч 1970-аад оны эдийн засгийн хямралын үед үр нөлөө нь суларсан бөгөөд шинэ чиглэл бий болох шаардлага, нөхцөл байдал тулгарсан. Учир нь Кейнсийн судалгаанд нийт хувьсагчдыг бизнесийн мөчлөгт ихээхэн нөлөөтэй гэж үзэж тайлбарласан байдаг. 1976 онд Роберт Лукас үүнийг няцааж “Лукасын шүүмж” хэмээх бүтээлээ хэвлүүлснээр шинэ сонгодог макро эдийн засгийн онолын тулгын чулууг тавьсан. Макро эдийн засгийн бодлогын өөрчлөлт гарах бүрт нийт хувьсагчид өөрчлөгдөж байсан нь бодлогын үр нөлөөт байдал, цаашдын шийдвэрийн уялдааг бууруулж байсныг Лукас ажигласан ба энэ тохиолдолд микро суурь хэмээх ойлголтыг ашиглах нь илүү үр дүнтэй гэж шүүмждээ дурджээ. Кидланд, Прескоттын 1982 онд хэвлүүлсэн судалгааны өгүүлэл Лукасын шүүмжийг дэлгэрүүлж бизнесийн мөчлөгийн хэлбэлзэлд нийлүүлэлтийн шинжтэй, бодит шок томоохон нөлөөтэй гэж



үзжээ. Тэр дундаа технологийн дэвшлийн шок мөчлөгийн өөрчлөлтөд 70 хүртэл хувийн нөлөөтэй болохыг тайлбарласан байна. Технологийн дэвшил нь урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмждэг ба үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлдэг нөлөөтэй аж. Тиймээс ч тэд бизнесийн мөчлөг, эдийн засгийн өсөлт хоёр нь ижил судлагдахуун гэж нэгдсэн ойлголтыг бий болгосон. Урд нь бизнесийн мөчлөгийг эдийн засгийн өсөлт, бууралтаас тусад нь судалж, тайлбарладаг байсан нь ойлголтын зөрүүтэй байдал үүсгэдэг байжээ.

Хэдийгээр өнөө цагт нийлүүлэлтийн гаралтай шокын бизнесийн мөчлөг дэх үр нөлөө илэрхий байгаа боловч тухайн үед энэ нь цоо шинэ ойлголт байсан юм. Тэд асуудлыг бүрэн шийдвэрлээгүй ч, шийдвэрлэх гарцыг бий болгож, үзэл санааны томоохон дэвшил авчирж чадсан. Нөгөөтэйгүүр тэд судалгааны арга зүйд микро суурь хэмээх ойлголтыг дэлгэрүүлэн тайлбарласнаараа гавьяатай юм. Кейнсийн өсөлтийн онолд нийт хувьсагчид судалгааны үндэс болдог бол шинэ сонгодог эдийн засгийн онолд микро суурь ижил утгатайгаар ашиглагддаг. Бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад нарийн параметр буюу айл өрх, бизнес эрхлэгчид зэрэг эдийн засагт оролцогч тус бүрийн зан төлвийг судалж, ашиглах нь өндөр үр дүнтэй байдаг аж.

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ 2018

Эцэг эх бүр үр хүүхдээ өв тэгш хүмүүжүүлэхийн төлөө байгаа бүхнээ зориулдаг. Зөв дадал хэвшил, боловсон харилцаа, өргөн мэдлэг боловсрол олгох нь мэдээж маш чухал. Гэхдээ ихэнх эцэг эхчүүдийн нэг их анзаардаггүй зүйл бол хүүхдээ мөнгөтэй хэрхэн зөв харьцахад төдий л ач холбогдол өгдөггүй юм. Гэтэл нийгмийн харилцаанд бие даан орохын цагт таны хүүхдэд хамгийн түрүүнд тулгарах асуудлуудын нэг нь олсон мөнгөө хэрхэн зөв удирдах ухаан юм. Санхүүгийн эрх чөлөөнд хүрэх эхний алхам ердөө эндээс л эхэлдэг болохыг өнөө бид ойлгох шаардлагатай болж байна. Хувь хүний энэхүү хандлага нь зөвхөн өөрт нь хэрэгтэй бус улсын нийт эдийн засгийн ашигтай эс болон үржих дэмжлэг болж байдаг. Харамсалтай нь үүнийг хүн төрөлхтөн саяхнаас буюу 2008 оны Дэлхийн санхүүгийн хямралаар олж мэдэж, түүнээс хойш олон улсын санхүүгийн байгууллагууд төдийгүй улс орнууд олон нийтийн санхүүгийн боловсролд идэвхтэй анхаарлаа хандуулдаг болж, олон төсөл хөтөлбөрийг өөрийн өөрийн чиглэлээр хэрэгжүүлж байна. Бид энэ удаад 2013 оноос хойш дэлхийд түгж буй “Мөнгөний долоо хоног” өдөрлөгийн тухай танилцуулахаар бэлтгэлээ.

“Child&Youth International” олон улсын байгууллагаас санаачлан 2013 оноос эхлэн “Мөнгөний долоо хоног” өдөрлөгийг жил бүрийн 03 дугаар сарын 12-18-нд дэлхийн хэмжээнд зохион байгуулдаг уламжлалыг тогтоогоод байна. Энэ хугацаанд 137 орны 23,738 байгууллага тус өдөрлөгт нэгджээ. Харин манай улс 2017 оноос тэмдэглэдэг болоод байна. Тус өдөрлөг нь ихэвчлэн хүүхэд залууст чиглэгдсэн байх ба тэднийг өөрсдийн санхүүгийн мэдлэг, туршлага дээрээ үндэслэн

амьдралынхаа туршид санхүүгийн зөв шийдвэр гаргадаг байх чадварыг хөгжүүлэхэд гол ач холбогдол нь оршиж байгаа юм.

“Дэлхийн мөнгөний долоо хоног”-ийн хүрээнд зохион байгуулагддаг үйл ажиллагааны төрөл, цар хүрээ жил ирэх тусам тэлж, тэр хэмжээгээр хамтран оролцогч улс орон, байгууллагууд, мэдлэгийг хүлээн авагч хүүхэд залуусын тоо өсөн нэмэгдэж байна.

“Дэлхийн мөнгөний долоо хоног”-оор ямар арга хэмжээнүүд зохиогддог вэ?

- Ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудад тусгай сургалт явуулдаг
- Санхүүгийн мэргэжлийн шинжээчдийн мэдлэг туршлагаас хуваалцдаг
- Төв банк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, Хөрөнгийн бирж зэрэг санхүүгийн томоохон байгууллагуудаар танилцах аялал хийдэг
- Арилжааны банкууд нээлттэй хаалганы өдөр зохион байгуулдаг
- Санхүүгийн байгууллагуудын хооронд дугуй ширээний уулзалтууд хийдэг
- Төрөл бүрийн хөгжөөнт тэмцээн зохион байгуулдаг
- Тухайн улсын Эрдэнэсийн сан хөмрөгийг үзэх зэргээр хүүхэд залуучуудыг санхүүгийн мэдээллээр хангадаг.

“Дэлхийн мөнгөний долоо хоног”-т хүүхдэд зориулсан ямар сэдвүүдийн хүрээнд сургалт хийдэг вэ?

10-14 насны хүүхдүүдэд дараах сэдвүүд хүрнэ

1. Хүсэл үү? Хэрэгцээ юу?
2. Хуримтлал
3. Миний данс
4. Нөөцийг хэмнэх
5. Төсөвтэй танилцах
6. Хуримтлалын төсөв
7. Үйл ажиллагааны төлөвлөгөө
8. Амьдралын зорилго
9. Миний ирээдүй

15-18 насны хүүхдүүдэд дараах сэдвүүд хүрнэ

1. Төсөвлөлт
2. Зарцуулалт
3. Мөнгө хэмнэх талаар сурах
4. Мөнгө зарцуулах талаар сурах
5. Төсөв зохиох
6. Хуримтлалын сонголтууд
7. Зээл авах

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ МОНГОЛД

Монгол Улс ч мөн “Дэлхийн мөнгөний долоо хоног-2018”-д нэгдсэнээр нэгэн долоо хоногийн турш мөнгөний талаарх ойлголт, мэдлэгийг хүүхэд залууст өгөх цуврал өдөрлөгүүдийг амжилттай зохион байгуулсан юм. Энэ өдрүүдэд Монголбанк, Монголын Банкны Холбоо, арилжааны банкууд хамтран ерөнхий

боловсролын сургуулийн ахлах ангийн 700 сургачдад “Мөнгөний асуудал бол чухал” сэдвээр хичээл орж, “Глобал” сургууль, 1 дүгээр сургуулийн нийт 80 сурагч Төв банкны Эрдэнэсийн сангаар зочлохын хамт “Төв банкны бодлого иргэдэд хэрхэн нөлөөлдөг вэ”, “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” сэдвээр илтгэл сонсоцгоов.

GLOBAL
MONEY
WEEK®



Join Global Money Week,
because Money Matters Matter

12 - 18 March 2018

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ 7 хоног 2018

“Мөнгөний асуудал бол чухал”

03.12-03.18

Монголбанк

**GLOBAL
MONEY
WEEK®**



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНГИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



MBA
MONGOLIAN BANKERS ASSOCIATION



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
Credit Insurance Corporation of Mongolia



MUK
MONGOLIAN MORTGAGE CORPORATION
МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ



БИЧИЛ САНХҮҮГИЙН
ХӨГЖЛИЙН САН



ADB



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ АЯН

2018 01.02-05.31